

ДОРНОД АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



Зорилтод эмзэг бүлгийн иргэд нийгмийн халамжийн үйлчилгээнд
бүрэн хамрагдаж чадахгүй байна.

ГҮЙЦЭТГЭЛИЙН АУДИТЫН ТАЙЛАН

“Аймгийн халамжийн сангийн үйл ажиллагааны үр нөлөө”-нд
хийсэн аудитын тайлан

АУДИТЫН КОД: ДОА-2022/32-ШТА-ГА

Чойбалсан хот
2022 он

Дорнод аймаг дахь Төрийн аудитын газрын дарга,
Тэргүүлэх аудитор Б.Болортуул
Утас: 7058-4203, Цахим хаяг: bolortuulb@audit.gov.mn

Ахлах аудитор Б.Батжаргал, Д.Нармандах
Утас: 7058-4207, Цахим хаяг: batjargalb@audit.gov.mn,
narmandakh@audit.gov.mn
Аудитор М.Ухаанбилэг, Б.Одхүү, Б.Оюунхэрлэн, М.Ганбилэг
Утас: 7058-4207, Цахим хаяг: ukhaanbilegm@audit.gov.mn
odkhuub@audit.gov.mn
oyunherlenb@audit.gov.mn
ganbilegm@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг
дараах хаягаар авна уу. Цахим хуудас: www.audit.mn

Аудитын тайланг бэлтгэсэн:	АГУУЛГА
Дорнод аймаг дахь Төрийн аудитын газар	Товчилсон үгийн тайлбар.....3
Аудитын III баг	Хүснэгт, дүрслэлийн товьёг.....4
Дарга, Тэргүүлэх аудитор Б.Болортуул	Аудитын зорилт, хамарсан хүрээ, стандарт, арга зүйн талаарх мэдэгдэл.....5
Ахлах аудитор: Б.Батжаргал Д.Нармандах	Бүлэг 1. “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлоготой уялдуулан нийгмийн халамжийн тухай хууль, журам, зааварт өөрчлөлт, шинэчлэлт хийгээгүй байна.....6
Аудитор: М.Ухаанбилэг Б.Одхүү Б.Оюунхэрлэн М.Ганбилэг	1.1. Нийгмийн халамжийн тухай хуульд заасан “Нийгмийн халамж” гэсэн тодорхойлолттой нийцэхгүй үйлчилгээнүүдийг халамжийн сангаас үзүүлж байна6-7 1.2. Халамжийн үйлчилгээнд шаардлагатай хөрөнгийг бодитой төлөвлөөгүй байна.....7-9
Аудитын тайлан, дүгнэлттэй холбоотой асуудлаар нэмж тодруулах, асууж лавлах зүйл байвал 7058-4203, 7058-4207 утсаар лавлана уу.	Бүлэг 2. Зорилтод эмзэг бүлгийн иргэд нийгмийн халамжийн үйлчилгээнд бүрэн хамрагдаж чадахгүй байна.....9 2.1. Халамжийг хавтгайруулан олгож, зорилтод эмзэг бүлэгт чиглүүлээгүй байна.....9-12 2.2. Халамжийн үйлчилгээг үзүүлэхдээ давхцалыг тооцож үздэггүй байна12-18 2.3 Халамжийн сангийн хөрөнгийг үр нөлөөтэй зарцуулаагүй байна.....18-21 2.4 Хүнс тэжээлийн дэмжлэг олгох үйлчилгээг үр нөлөөтэй хэрэгжүүлээгүй байна.....21-24
Хаяг: Дорнод аймаг, Хэрлэн сум, 7-р баг, аймгийн ЗДТГ-ын II байр, 05 тоот	Бүлэг 3. Халамжийн сангийн хөрөнгийн зарцуулалтад тавих дотоод хяналт үр нөлөөгүй байна.....24 3.1. Халамжийн сангийн үйл ажиллагааны тайлан, мэдээг хугацаанд нь тайлагнасан байна.....24-25 3.2. Халамжийн сангийн хөрөнгийн зарцуулалтад дотоод хяналт, шалгалтыг үр дүнтэй зохион байгуулаагүй байна.....25-36
2022 оны 11 дүгээр сар	ХОЛБОГДОХ БАЙГУУЛЛАГЫН САНАЛ:.....27 ДҮГНЭЛТ:28 САНАЛ:28 ЗӨВЛӨМЖ:29 ТУШААЛ.....30-31 АЛБАН ШААРДЛАГА.....32-40

Товчилсон үгийн тайлбар

АДБОУС	Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт
ААН	Аж ахуй нэгж
ТББ	Төрийн бус байгууллага
ЗДТГ	Засаг даргын Тамгын газар
ИТХ	Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал
ИНХ	Иргэдийн нийтийн хурал
МУЕА	Монгол Улсын Ерөнхий аудитор
MNS	Mongolian national standard
МУЗГ	Монгол Улсын Засгийн газар
НӨАТ	Нэмэгдсэн өртгийн албан татвар
ХХҮЕГ	Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газар
ХХҮГ	Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар
ХБИ	Хөгжлийн бэрхшээлтэй иргэн
ХНХС	Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд

Хүснэгтийн товъёг

№	Тайлбар	Хуудасны дугаар
Хүснэгт 1	Улсын төсөв. Халамжийн сангийн төсвийн төслийн тооцоолол	8
Хүснэгт 2	Улсын төсөв. Халамжийн сангийн дансны үлдэгдэл	8
Хүснэгт 3	Орон нутгийн төсөв. Халамжийн сангийн төсвийн тооцоолол	8
Хүснэгт 4	Орон нутгийн төсөв. Халамжийн сангийн дансны үлдэгдэл	9
Хүснэгт 5	Бэлэн мөнгөөр болон бэлэн бусаар үзүүлсэн халамжийн үйлчилгээний эзлэх хувь	10
Хүснэгт 6	Нийгмийн халамжийн үйлчилгээний төрөл, хамрагдахад тавигдах шалгуур	13-16
Хүснэгт 7	Хувийн хэрэгт бүрдүүлэх баримт материалын жагсаалт	17
Хүснэгт 8	Аймгуудын хүн амд ХБИ эзлэх хувь	19
Хүснэгт 9	Сумдын хүнсний эрхийн бичигт хамрагддаг өрх-иргэдийн судалгаа	22

Дүрслэлийн товъёг

№	Тайлбар	Хуудасны дугаар
Дүрслэл 1	Хүнсний эрхийн бичигт хамрагддаг өрх, иргэдийн тоо 2020-2022 он	21
Дүрслэл 2	Хүнсний эрхийн бичигт хамрагддаг иргэдийн насны ангилал	23

Аудит хийх үндэслэл, бүрэн эрх	Аудитын зорилт, хамарсан хүрээ, стандарт, арга зүйн талаарх мэдэгдэл
	Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1-д заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Монгол Улсын Ерөнхий аудиторын 2022 оны А/11 дүгээр тушаалаар баталсан “Аудитын сэдэв батлах тухай”, А/12 дугаар тушаалаар баталсан “Төрийн аудитын байгууллагын 2022 онд гүйцэтгэх аудитын төлөвлөгөө”-г үндэслэн гүйцэтгэлийн аудитыг хийлээ.
Аудитын зорилт	Аймгийн халамжийн сангийн үйл ажиллагааны үр нөлөөг тооцож, дүгнэлт, зөвлөмжийг боловсруулж, холбогдох байгууллага, албан тушаалтанд танилцуулахад аудитын зорилго чиглэнэ. Аудитын зорилгыг хангахын тулд дараах дэд зорилтын хүрээнд гүйцэтгэнэ. Үүнд:
	1. Халамжийн сангийн бодлого үр нөлөөтэй, сангийн хөрөнгийг үндэслэлтэй төлөвлөсөн эсэх; 2. Халамжийн үйлчилгээг хууль, журмын дагуу үзүүлж, сангийн хөрөнгийг үр нөлөөтэй зарцуулсан эсэх; 3. Халамжийн сангийн мэдээллийг хууль, журмын дагуу тайлагнаж, санд тавих хяналтыг үр дүнтэй хэрэгжүүлсэн эсэх;
Аудитын хамарсан хүрээ	Аймгийн халамжийн сангийн 2020-2022 оны төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, тайлагнал, хяналт, аймаг, сумын ИТХ, ЗДТГ, баг, хороодын ИНХ, Засаг даргын халамжийн сантай холбоотой үйл ажиллагааг хамруулсан.
Аудитын арга зүй, шалгуур үзүүлэлт	Аудитыг гүйцэтгэлийн аудитын стандарт АДБОУС 3000-3100, Монгол Улсын Төрийн аудитын стандарт, MNS 6817-5:2020 “Гүйцэтгэлийн аудитын зарчим”, MNS 6817-7:2020 “Гүйцэтгэлийн аудитын стандарт”, МУЕА-ын баталсан “Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журам”, “Гүйцэтгэлийн аудитын заавар, аргачлал”-ыг ашиглан холбогдох албан тушаалтнуудтай ярилцлага хийх, асуулга, тодруулга болон судалгаа авах, харьцуулах, нэгтгэх, дүн шинжилгээ хийх зэрэг арга зүйг ашиглан аудитын хөтөлбөр, асуудлын шинжилгээний дагуу нотлох зүйл цуглуулж, аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж боловсруулав.
Аудитын бүрэлдэхүүн, хугацаа	Аудитыг Дорнод аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор Б.Болортуул хянан удирдаж, ахлах аудитор Б.Батжаргал, Д.Нармандах, аудитор М.Ухаанбилэг, Б.Одхүү, Б.Оюунхэрлэн, М.Ганбилэг нар төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу хийж гүйцэтгэв. Аудитын талбарын ажлыг 2022 оны 7 дугаар сарын 18-ны өдрөөс 2022 оны 9 дүгээр сарын 30-ны өдрийг хүртэл гүйцэтгэж, тайланг 10 дугаар сарын 28-ны өдрийн дотор боловсруулж, үе шатны хяналтыг хийлгэж, тайланг 11 дүгээр сарын 15-нд Үндэсний аудитын газар болон холбогдох байгууллага, албан тушаалтанд хүргүүллээ.

БҮЛЭГ 1. “АЛСЫН ХАРАА-2050” МОНГОЛ УЛСЫН УРТ ХУГАЦААНЫ ХӨГЖЛИЙН БОДЛОГОТОЙ УЯЛДУУЛАН НИЙГМИЙН ХАЛАМЖИЙН ТУХАЙ ХУУЛЬ, ЖУРАМ, ЗААВАРТ ӨӨРЧЛӨЛТ, ШИНЭЧЛЭЛТ ХИЙГЭЭГҮЙ БАЙНА.

1.1 “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлоготой уялдуулан Нийгмийн халамжийн тухай хууль, журам, зааварт өөрчлөлт, шинэчлэлт хийгээгүй байна.

1.1.1 “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлоготой уялдуулан Нийгмийн халамжийн тухай хууль, журам, зааварт өөрчлөлт, шинэчлэлт хийгээгүй байна.

Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуульд бодлого төлөвлөлтийг нэгдмэл, цогц, харилцан уялдаатай байхаар заасан.

Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх үндсэн чиглэл, МУЗГ-ын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрүүдэд заасан хөдөлмөр, нийгмийн хамгааллын чиглэлээрх зорилго, зорилтуудыг аймгийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны мөрийн хөтөлбөр, Дорнод аймгийг 2021-2025 хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл, жилийн хөгжлийн төлөвлөгөөнд тусгаж баталсан байна.

Дорнод аймгийн хэмжээнд 2021 оны жилийн эцсийн байдлаар нийгмийн халамжийн үйлчилгээнд давхардсан тоогоор 75957 иргэн хамрагдсан байна. Үүнээс 31095 хүүхэд хүүхдийн мөнгөн тэтгэмж авсан байна.

“Алсын хараа-2050”-д заасан амьдралын баталгааг хангах нийгмийн хамгааллын үйлчилгээг хөгжүүлэх зорилтын хүрээнд хэрэгжүүлэх 3.1.10 *Нийгмийн халамжийн тусламж, дэмжлэг, үйлчилгээг зорилтот, эмзэг бүлгийн хэрэгцээнд нийцүүлж, амьжиргааг нь дээшлүүлэхэд чиглүүлнэ.*” гэсэн зорилтын хүрээнд хуулийн өөрчлөлт шинэчлэлт хийгээгүй байна.

Нийгмийн халамжийн тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1 **“нийгмийн халамж”** гэж эрүүл мэндийн доройтолтой, гэр бүлийн халамж, асрамж дутагдалтай, бие даан, эсхүл бусдын тусламжгүйгээр хэвийн амьдрах боломжгүй, өвөрмөц хэрэгцээ бүхий иргэн, нийгмийн халамжийн дэмжлэг, туслалцаа зайлшгүй шаардлагатай өрхийн гишүүн-иргэнд наад захын хэрэгцээг нь хангах зорилгоор улсаас тэтгэвэр, тэтгэмж олгох, тусгайлсан үйлчилгээ үзүүлэх үйл ажиллагааг; заасан. гэтэл хүн амын өсөлтийг дэмжсэн хүүхдийн мөнгө, цалинтай ээж хөтөлбөр, эхийн алдар одонгийн мөнгө, насны хишиг, ахмадын амралтын хөнгөлөлт зэрэг хуульд заасан нийгмийн халамж гэсэн тодорхойлолттой нийцэхгүй үйлчилгээнүүдийг халамжийн сангаас олгож байна.

Нийгмийн халамжийн тухай хуулийн 27 дугаар зүйлд Амьжиргаа дэмжих зөвлөлийг “27.2 Зөвлөлийн бүрэлдэхүүнийг сум, хорооны Засаг даргын санал болгосноор сум, хороонд иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчид, иргэдийн Нийтийн Хурлаар хэлэлцэж батална.” гэж заасан. Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуульд сумын ИТХ-ын Тэргүүлэгч гэсэн субъект байхгүй болсон байна.

Нийгмийн халамжийн тухай хуульд заасан боловсролыг дэмжих үйлчилгээ /сургуулийн өмнөх боловсролын болон ерөнхий боловсролын сургуульд сурч байгаа бол хичээлийн хэрэгсэл, сурах бичиг, дүрэмт хувцасны үнийн хөнгөлөлт/, мөн гэр оронгүй, тэнэмэл амьдралтай иргэнд халуун хоол, цайгаар үйлчлэх гэсэн заалтууд бодит амьдрал дээр хэрэгждэггүй байна.

1.1.2 Халамжийн бодлого нь хөдөлмөр эрхлэлтийг дэмжих бодлоготой үр дүнтэй уялдахгүй байна.

Аймгийн хэмжээнд 2017-2020 онд зорилтод бүлгийн иргэдийг хамруулсан “Хөгжлийн бэрхшээлтэй иргэний ажлын байрыг дэмжих хөтөлбөр”-т 353.0 сая төгрөг 512 хүн, “Ахмад мэргэжилтний зөвлөх үйлчилгээг хөгжүүлэх хөтөлбөр”-т 140.2 сая төгрөг 278 хүн, “Хөдөлмөрт бэлтгэх, хөдөлмөр эрхлэлтийн ур чадвар олгох хөтөлбөр”-т 114.0 сая төгрөг 872 хүнийг тус тус хамруулсан байна.

“Алсын хараа-2050”-д эмзэг бүлгийн өрхийн нэг гишүүнийг ажлын байраар хангах бодлого баримтална.” гэж заасан. ХНХЯ-аас эмзэг бүлгийн өрхийн нэг гишүүнийг ажлын байраар хангах бодлогыг баримталсан хөтөлбөр гаргаагүй байна.

Аймгийн хэмжээнд дээрх зорилтыг баримталсан Дорнод аймгийн ИТХ-ын тэргүүлэгчдийн 2020 оны 85 дугаар тогтоолоор “Нэг өрх-нэг ажлын байр” хөтөлбөрийг баталсан байна. Хөтөлбөрийг 2021-2024 он хүртэл хэрэгжихээр зааж, зорилтод бүлгийн 400 өрх иргэнийг ажилтай, орлоготой болгохоор баталсан байна. Аймгийн төсвөөс “Нэг өрх-нэг ажлын байр” хөтөлбөрт 2021 онд 10.0 сая төгрөг баталж 3 өрхийг хамруулсан. Мөн 2022 онд 10.0 сая төгрөг баталсан байгаа нь хангалтгүй үзүүлэлт бөгөөд 2024 он гэхэд уг хөтөлбөрөөр 400 өрх иргэнийг ажилтай орлоготой болгож чадахгүй байх нөхцөл байдалтай байна.

Үндэсний статистикийн хорооноос хоёр жил тутамд ядуурлын түвшний судалгаа явуулдаг. Хамгийн сүүлийн буюу 2020 оны судалгаагаар Дорнод аймгийн ядуурлын түвшин 37.1 хувь байгаа нь улсын түвшнээс 9.1 хувиар өндөр байна. Мөн ажилгүйдлийн түвшин 2022 оны 2 дугаар улирлын байдлаар 9.0 хувьтай байгаа нь улсын түвшнээс 1.2 хувиар өндөр байна. Эдгээр үзүүлэлтээс харахад аймгийн хэмжээнд зорилтод бүлэгт чиглэсэн ажилгүйдэл, ядуурлыг бууруулах төсөл, хөтөлбөрүүдийг үр дүнтэй хэрэгжүүлэх шаардлага байна.

1.1.3 Халамжийн бодлогод тэтгэмжийн үйлчилгээнээс бусад халамжийн үйлчилгээг хөдөлмөрийн хөлсний доод хэмжээтэй харьцуулан олгох бодлого байхгүй байна.

Нийгмийн халамжийн сангийн 10 төрөлд хамаарах 72 үйлчилгээний зөвхөн нэг үйлчилгээ болох гурав болон түүнээс дээш хүүхэдтэй өрх толгойлсон эх, эцгийн тэтгэмжийн хэмжээ нь хөдөлмөрийн хөлсний доод хэмжээтэй тэнцүү байхаар заасан байна. Бусад халамжийн үйлчилгээний хувьд амьжиргааны доод түвшинтэй уялдуулан тогтоохоор зохицуулсан байна

Халамжаар олгож байгаа мөнгөн дүн нь хөдөлмөрийн хөлсний доод хэмжээнээс харьцангуй бага байна. Учир нь нийгмийн халамжаар олгож байгаа мөнгө нь нийгмийн халамжийн дэмжлэг, туслалцаа зайлшгүй шаардлагатай өрхийн гишүүн-иргэнд наад захын хэрэгцээг нь хангах зорилготой олгодогтой холбоотой байна.

1.2 Халамжийн үйлчилгээнд шаардлагатай хөрөнгийг бодитой төлөвлөөгүй байна.

1.2.1 Халамжийн сангийн арилжааны банкин дахь дансны үлдэгдэл болон хүүгийн орлогыг тооцон төлөвлөж, төвлөрүүлсэн байна.

Хөдөлмөр халамжийн үйлчилгээний ерөнхий газар, сангийн яам, арилжааны банктai гуравласан гэрээ байгуулж, халамжийн сангийн арилжааны банкин дахь дансанд 0.3 хувийн хүү тооцож олгосон байна. Аймгийн халамжийн сангийн арилжааны банкин дахь дансанд 2020-2021 онд нийт 4.888,5 мянган төгрөгийн хүү тооцож олгосныг сангийн яамны холбогдох дансанд төвлөрүүлсэн байна. Халамжийн сангаас үзүүлэх үйлчилгээнүүд цахимд шилжсэнээр 2022 оноос

арилжааны банканд байршиж байсан данс хаагдсан байна. Халамжийн сангаас үзүүлэх үйлчилгээний мөнгийг сангийн яам, Монгол банкаар дамжуулан иргэдийн дансанд шилжүүлдэг болсон байна.

1.2.2 Халамжийн үйлчилгээнд шаардлагатай хөрөнгийг тооцоо судалгаанд үндэслэн төлөвлөөгүй байна.

Халамжийн сангийн төсвийн төслийг боловсруулахдаа тооцоо судалгаа хийсэн баримт байхгүй байна. Төсвийн төслийг сүүлийн 3 жилийн гүйцэтгэлийн дунджаар төлөвлөсөн гэсэн тайлбарыг өгсөн боловч дахин тооцож үзэхэд дунджаас өндрөөр төлөвлөсөн байна.

Улсын төсвөөс санхүүжих халамжийн сангийн хөрөнгийн төсвийн төсөл боловсруулсныг дахин тооцож үзэхэд:

Улсын төсөв	Төсвийн гүйцэтгэл			2022 оны төлөвлөх дүн	2022 оны төсвийн төсөл	Зөрүү
	2019 он	2020 он	2021 он	3 жилийн дундаж		
хүний тоо	48246	47594	44435	46758	48550	1792

Эх сурвалж: аймгийн халамжийн сангийн 2019-2021 оны санхүүгийн тайлан

Улсын төсвөөс авах санхүүжилтийг өмнөх жилүүдийн дунджаас өндрөөр төлөвлөж хүргүүлдэг ч батлагдахдаа өмнөх оны гүйцэтгэлээр батлагдан ирдэг байна. Мөн батлагдсан төсвөөс 2020 онд 210.8 сая төгрөг, 2021 онд 174.2 сая төгрөг үлдэж улсын төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Үзүүлэлт	Дансны үлдэгдэл	
	2020 он /сая.төг/	2021 он /сая.төг/
Улсын төсөв	210.8	174.2

Эх сурвалж: аймгийн халамжийн сангийн 2020-2021 оны санхүүгийн тайлан

Дээрхээс дүгнэхэд халамжийн сангийн төсвийн төслийг тооцоо судалгаанд үндэслэн боловсруулаагүй байна.

1.2.3 Орон нутгийн төсвөөс халамжийн үйлчилгээнд зарцуулах хөрөнгийг тооцоо судалгаанд үндэслэн төлөвлөөгүй байна.

Орон нутгийн төсвөөс санхүүжих халамжийн сангийн хөрөнгийн төсвийн төсөл боловсруулсныг дахин тооцож үзэхэд:

Орон нутгийн төсөв	Төсвийн гүйцэтгэл			2022 оны төлөвлөх дүн	2022 оны төсвийн төсөл	Зөрүү
	2019 он	2020 он	2021 он	3 жилийн дундаж		
хүний тоо	471	454	362	423	571	148

Эх сурвалж: аймгийн халамжийн сангийн 2019-2021 оны санхүүгийн тайлан

Халамжийн сангийн төсвийн төслийг боловсруулахдаа тооцоо судалгаа хийсэн баримт байхгүй, сүүлийн 3 жилийн гүйцэтгэлийн дунджаас өндрөөр төлөвлөсөн байна.

Орон нутгийн төсвөөс авах санхүүжилтийг өмнөх жилүүдийн дунджаас өндрөөр төлөвлөж хүргүүлдэг ч батлагдахдаа өмнөх оны гүйцэтгэлээр батлагддаг байна.

Мөн батлагдсан төсвөөс 2020 онд 34.3 сая төгрөг, 2021 онд 53.0 сая төгрөг үлдэж орон нутгийн төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Дорнод аймаг дахь Төрийн аудитын газраас аймгийн төсвийн төсөлд санал дүгнэлтээр халамжийн сангийн 2021 оны төсвийн төслийг 37.4 сая төгрөг, 2022 оны төсвийн төслийг 59.8 сая төгрөгөөр тус тус бууруулах санал оруулж батлуулсан байна.

Хүснэгт 4

Үзүүлэлт	Дансны үлдэгдэл	
	2020 он /сая.төг/	2021 он /сая.төг/
Орон нутгийн төсөв	34.3	53.0

Эх сурвалж: аймгийн халамжийн сангийн 2020-2021 оны санхүүгийн тайлан

Дээрх дүгнэхэд орон нутгийн төсвөөс санхүүжих халамжийн сангийн төсвийн төслийг бодитой төлөвлөөгүй байна.

БҮЛЭГ 2. ЗОРИЛТОТ ЭМЗЭГ БҮЛГИЙН ИРГЭД НИЙГМИЙН ХАЛАМЖИЙН ҮЙЛЧИЛГЭЭНД БҮРЭН ХАМРАГДАЖ ЧАДАХГҮЙ БАЙНА.

2.1 Халамжийг хавтгайруулан олгож, зорилтод эмзэг бүлэгт чиглүүлээгүй байна.

2.1.1 Зорилтод эмзэг бүлгийн иргэд нийгмийн халамжийн үйлчилгээнд бүрэн хамрагдаж чадахгүй байна.

Зорилтод эмзэг бүлгийн иргэд гэж ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэн, хүнд нөхцөлд байгаа хүүхэд, мөн хүчирхийлэлд өртсөн, хорих ангиас суллагдсан, согтуурах, мансуурах донтох өвчтэй, эдгэшгүй хүнд өвчтэй хүн, гэр оронгүй тэнэмэл амьдралтай өрх, иргэн, шилжин суурьшсан нийгмийн халамжийн дэмжлэг туслалцаа шаардлагатай өрхийн гишүүн, өрх толгойлсон эх, эцгийг хэлдэг.

Мөн Нийгмийн халамжийн тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.2-д “нийгмийн халамжийн дэмжлэг, туслалцаа зайлшгүй шаардлагатай өрхийн гишүүн-иргэн” гэж Үндэсний статистикийн хороо, нийгмийн халамжийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага хамтран баталсан аргачлалын дагуу өрхийн мэдээллийн нэгдсэн санд орсон, амьжиргааны түвшин нь тухайн үеийн ядуурлын шугамаас доогуур өрхөөс сонгогдсон өрхийн гишүүнийг” гэж заасан байна.

Аудитаар Дорнод аймгийн Чойбалсан хотын төвлөрсөн хогийн цэг дээр ажиллаж, амьдардаг хүмүүсийн талаар Хэрлэн сумын 1-р багийн ажилтнуудтай хамтран 4 өдрийн турш ажиглаж, ярилцлага авч судалгаа хийлээ. Судалгаанд тогтмол хогийн цэг дээр ажилладаг 15, үүнээс тогтмол амьдардаг 2 хүн хамрагдсан. Зуны улиралд эдгээр иргэдийн тоо 2 дахин нэмэгддэг байна.

Эдгээр иргэдийн ард талд 31 хүүхэд, 4 хөгжлийн бэрхшээлтэй иргэн, 1 өндөр настан, насанд хүрсэн 16 иргэн, нийт 52 хүн амьдарч байна. Мөн хогийн цэг дээрх иргэдийн дунд ахмад настан 8, хөгжлийн бэрхшээлтэй 2 иргэн байна. Тэд Ахмад настны тухай хууль, Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуульд заасны дагуу нийтийн халаалтгүй сууц, гэрт амьдардаг иргэнд түлш худалдан авахад зориулан жилд нэг удаа мөнгөн тусламж олгох, хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг нийгмийн хамгааллын болон нийгмийн халамжийн төсөл, хөтөлбөрт хамрагдаагүй байна.

Мөн 27, 32, 35 насны 3 эмэгтэй 5-7 хүүхдийн хамт 8-11 ам бүлийг тэжээн амьдарч байна. Тэд халамжаас хүүхдийн мөнгө, хүнсний эрхийн бичиг авдаг ч амьдрал ахуйд нь хүрэлцдэггүй тул хогийн цэгээс хоёрдогч түүхий эд цуглуулан зарж борлуулан

амьдарч байна. Эдгээр иргэдийн эрүүл ахуй, ариун цэврийн шаардлага хангахгүй бохир орчинд ажиллаж байна.

фото зураг 1



Төвлөрсөн хогийн цэг дээрх иргэдийн нөхцөл байдалтай сум, багийн иргэдийн нийгмийн асуудлыг хариуцсан ажилтнууд биечлэн ирж үзээгүй байна. Эдгээр иргэд Засгийн газраас хэрэгжүүлсэн “Зорилтот өрхийн хөгжил, хамгааллыг сайжруулах үндэсний хөтөлбөр”, орон нутгаас хэрэгжүүлж буй хөдөлмөр эрхлэлтийг дэмжих төсөл хөтөлбөрт хамрагдаагүй байна.

2.1.2 Халамжийн үйлчилгээний 96.5 хувийг иргэдэд бэлэн мөнгөөр олгож үзүүлсэн байна.

Халамжийн сангийн 2021 оны зарцуулалтын судалгаанаас нийт зарцуулалтын 96.5 хувийг иргэдэд бэлэн мөнгөөр олгосон байна.

Хүснэгт 5

№	Төрөл	Хүний тоо	Мөнгөн дүн /мянган төгрөг/	Эзлэх хувь	Эрэмбэ
	Бэлэн мөнгөөр олгосон халамж				
1	Нийгмийн халамжийн тэтгэвэр	1,946	5,605,122.1	10.7	II
2	Нийгмийн халамжийн тэтгэмж	3,018	2,627,179.0	5.0	IV
3	Олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээ	293	46,783.5	0.09	
4	Эх олон хүүхэдтэй өрх толгойлсон эх, эцэгт тэтгэмж олгох хууль	8,177	3,217,105.4	6.1	III
5	Ахмад настны тухай хууль	6,985	301,163.6	0.6	
6	Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хууль	1,420	272,684.0	0.5	
7	Алдар цолтон ахмад настанд төрөөс нэмэгдэл, хөнгөлөлт олгох тухай хууль	27	4,012.0	0.0	
8	Хүүхдийн мөнгөн тэтгэмж	31,238	37,167,400.0	70.7	I
9	Одонтой ээжийн мөнгөн тусламж	6,948	902,900.0	1.7	
10	Насны хишиг	3,757	579,790.0	1.1	
	Бэлэн бусаар олгосон халамж				
1	Хоол тэжээлийн дэмжлэг	12,148	1,836,549.0	3.5	
2	Амьжиргааг дэмжих зөвлөл	78	15,057.0	0.029	
	Дүн	76,035	52,575,746	100	-

Эх сурвалж: аймгийн халамжийн сангийн 72 нэр төрлийн зарцуулалтын судалгаа

Хүснэгтээс харахад 70.7 хувь буюу 37.2 тэрбум төгрөгийг хүүхдийн мөнгөн тэтгэмжид, 10.7 хувь буюу 5.6 тэрбум төгрөгийг халамжийн тэтгэвэрт, 6.1 хувь буюу 3.2 тэрбум төгрөгийг өрх толгойлсон эх, эцэгт олгосон байна.

Мөн халамжийн үйлчилгээний талаар орон нутгийн 320 иргэдээс авсан судалгааны дүнгээс харахад 68,4 хувь буюу 219 хүн халамжийг бэлэн мөнгөөр олгох нь зөв, 31,6 хувь буюу 101 хүн буруу гэж хариулсан байна.

Засгийн газрын “Коронавируст халдвар (covid-19)-ын цар тахлын үед эдийн засгийг идэвхжүүлэх, иргэдийн амьжиргааг дэмжих нийгмийн хамгааллын зарим арга хэмжээний тухай” 2020 оны 167 дугаар тогтоолын 5.1-д “18 хүртэлх насны хүүхэд бүрд олгож байгаа хүүхдийн мөнгөн тэтгэмжийг нэмэгдүүлж 2020 оны 4 дүгээр сарын 01-ний өдрөөс сар бүр 100 000 (нэг зуун мянган) төгрөг олгох”, 5.3-д “нийгмийн халамжийн сангаас олгож байгаа халамжийн тэтгэвэр болон байнгын асаргаа шаардлагатай 16 хүртэлх насны хүүхдийн амьжиргааг дэмжих мөнгөн тэтгэмжийн хэмжээг нэмэгдүүлж 2020 оны 5 дугаар сарын 01-ний өдрөөс 2023 оны 01 дүгээр сарын 01-ний өдөр хүртэлх хугацаанд сар бүр 288 000 (хоёр зуун наян найман мянган) төгрөг олгох”- оор тус тус шийдвэрлэж олгож байгаа нь эдийн засгийн хямралтай, зах зээл дэх өргөн хэрэглээний бараа бүтээгдэхүүний үнийн өсөлт нэмэгдсэн энэ үед ард иргэдийн амьдралд бодит дэмжлэг болж, үр дүнгээ өгч байна.

Нийгмийн халамжийн хэлтсээс иргэдийн амьжиргаанд халамжийг бэлэн болон бэлэн бусаар олгосны давуу болон сул талыг харьцуулсан тооцоо судалгаа хийж, эдийн засгийн өсөлттэй уялдуулан бэлэн мөнгө олгох хэлбэрээр хэрэгжүүлж байгаа халамжийн үйлчилгээг бууруулах, хөдөлмөр эрхлэлт, ажлын байрыг дэмжихэд чиглэсэн халамжийн үйлчилгээг нэмэгдүүлэх шаардлагатай байна.

2.1.3 Халамжийн цахим сан дахь мэдээлэл бусад төрийн байгууллагуудын мэдээлэлтэй уялдсан байна.

Дорнод аймгийн халамжийн хэлтэс нь ehalamj.mn халамжийн нэгдсэн систем болон heb2017.hudulmur-halamj.gov.mn өрхийн мэдээллийн нэгдсэн сан-Хүнсний эрхийн бичиг үйлчилгээний онлайн системийг ашиглан халамжийн үйлчилгээг үзүүлж байна.

Нийгмийн халамжийн сангийн ehalamj.mn халамжийн нэгдсэн систем нь Төрийн мэдээлэл солилцооны “Хур” системээр дамжуулан Улсын бүртгэлийн хэлтсийн шинэ төрсөн хүүхэд, нас баралт, иргэдийн шилжилт хөдөлгөөнийг улсын бүртгэлийн нэгдсэн сантай, Нийгмийн даатгалын хэлтсийн өндөр настны тэтгэвэр, тэжээгчээ алдсаны тэтгэвэр, хөдөлмөрийн чадвараа алдсан иргэний тэтгэвэр зэрэг үйлчилгээг нийгмийн даатгалын сангийн нэгдсэн сантай, өрхийн эмнэлгийн эмч нартай хөдөлмөрийн чадвар алдалт байнгын асаргааны сунгалтыг тулган шалгадаг байна.

Харин нийгмийн халамжийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын үйл ажиллагаандаа ашиглаж буй хүнсний эрхийн бичгийн heb2017.hudulmur-halamj.gov.mn, ehalamj.mn, www.lmis.gov.mn программууд хоорондоо уялдаа холбоогүй байгаа нь өрхийн мэдээллийн нэгдсэн санг удирдах, ашиглах журмын 3.1-д "Нийгмийн халамжийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага мэдээллийн санд хадгалагдаж байгаа мэдээлэлд тухай бүр баяжилт хийн шинэчлэх бөгөөд өрх, хүн амын талаарх мэдээллийг бусад эх үүсвэртэй тулган шалгах, баталгаажуулах, шинэчлэх зорилгоор холбогдох төрийн байгууллагуудтай хамтран ажиллана" гэсэн заалттай нийцэхгүй байна.

Өрхийн мэдээллийн нэгдсэн санд нийгмийн халамжийн дэмжлэг туслалцаа шаардлагатай өрхийн гишүүн иргэнийг тодорхойлох орлогыг орлуулан тооцох аргыг

ашиглан 2010, 2013, 2016 онуудад “Өрхийн мэдээллийн нэгдсэн сангийн журам”-ын дагуу 3 жил тутамд шинэчлэлт хийж байсан бол дахин шинэчлэлт хийгдээгүй өнөөдрийг хүрээд байна.

Өрхийн мэдээллийн нэгдсэн санд байгаа хүнсний эрхийн бичигт хамрагдаж байгаа өрх иргэдийн амьжиргааны түвшингийн мэдээллийг 2016 оноос хойш шинэчлэн тогтоогоогүй байгаа нь МУ-ын Засгийн газрын 2014 оны 404-р тогтоолын хавсралтаар батлагдсан “Өрхийн мэдээллийн нэгдсэн сангийн удирдах ашиглах журам”-ын 2.3 дахь “Энэ журмын 2.1 заасан мэдээллийн санг бүрдүүлэхэд ашиглаж байгаа аргачлалыг нийгэм, эдийн засгийн өөрчлөлттэй уялдуулан 3 жил тутам шинэчилнэ” гэсэн заалттай нийцэхгүй байна.

2.1.4 Мэдээллийн ил тод байдлыг хангаж ажилласан байна.

Нийгмийн халамжийн тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.8 дахь хэсэгт “Нийгмийн ажилтан дор дурдсан үүрэг хүлээнэ”, 28.8.6 дахь заалтад “Орон нутгийн иргэн, аж ахуйн нэгж, төрийн болон төрийн бус байгууллагыг мэдээллээр хангах, мэргэжил, арга зүйн туслалцаа үзүүлж, хамтран ажиллах”, 28.8.11 дэх заалтад “Иргэнд нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмж, үйлчилгээний талаар бүрэн мэдээлэл өгөх”, 27 дугаар зүйлийн 27.1 дэх хэсэгт “Энэ хуулийн 3.1.2, 3.1.5, 18.2.4-т зааснаас бусад иргэнийг нийгмийн халамжийн үйл ажиллагаанд хамруулах эсэх талаар шийдвэр гаргах, халамжийн үйл ажиллагаатай холбогдсон гомдлыг хүлээн авч шийдвэрлэх үүрэг бүхий Амьжиргааг дэмжих орон тооны бус зөвлөл”, 27.7 дахь хэсэгт “Зөвлөлийн шийдвэр нь Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай хуульд зааснаас бусад тохиолдолд нийтэд нээлттэй, ил тод байна” гэж заажээ.

Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар нь мэдээллийн ил тод байдлыг хангах чиглэлээр Dornod.hudulmur-halam.gov.mn цахим хуудас, Shilendans.gov.mn, Дорнод-Хөдөлмөр халамжийн үйлчилгээний газар facebook цахим хуудас, хэвлэл мэдээлэл, сум багийн ажлын албаны болон байгууллагын мэдээллийн самбаруудаар дамжуулан халамжийн үйлчилгээний талаарх мэдээллийг хүргэж байна. Мөн сар бүхэн Халамжийн сангийн олголтын мэдээг Статистикийн хэлтэст, орон нутгийн төсвийн гүйцэтгэлийн мэдээг төрийн санд хүргүүлдэг байна.

Халамжийн үйлчилгээний талаарх мэдээллийг хаанаас авдаг вэ гэсэн иргэдээс авсан судалгаагаар 56.1 хувь нь ХХҮГ-аас, 23.1 хувь нь мэдээллийн хэрэгслээр, 13 хувь нь бусдаас, 7.8 хувь нь багийн ажлын албанаас гэсэн байна. Судалгаанаас багийн ажлын албанаас шаардлагатай мэдээллээ хангалттай авч чаддаггүй, ихэнх иргэд ХХҮГ-аас авдаг гэж хариулсан байна.

Цаашид багийн ажлын алба, нийгмийн ажилтан халамжийн үйлчилгээний талаарх мэдээллийг өөрийн багийн иргэдэд хүргэж, халамжийн үйлчилгээнд бүрэн хамруулж байх шаардлагатай.

2.2 Халамжийн үйлчилгээг хууль, журмын дагуу үзүүлсэн байна.

2.2.1 Амьжиргааг дэмжих зөвлөл нь хууль, дүрэмд заасан чиг үүргээ үр дүнтэй хэрэгжүүлээгүй байна.

Амьжиргааг дэмжих зөвлөлийн дүрэм, урамшууллын хэмжээг Нийгмийн хамгаалал, Хөдөлмөрийн сайдын 2012 оны А/89 дугаартай тушаалаар урамшууллын хэмжээг тогтоож, хавсралтаар дүрмийг нь баталсан байна.

Сумдын амьжиргаа дэмжих зөвлөлүүд нь дүрмийн 4.2.3-т “Зөвлөлийн шийдвэрийн дагуу Нийгмийн халамжийн тухай хууль тогтоомжид буй өрх, иргэний амьдралын нөхцөл байдалд гарч буй өөрчлөлтөд улирал бүр хяналт тавьж, санал, дүгнэлт гаргах, шаардлагатай бол холбогдох байгууллагад уламжлах.” 4.2.5-т “Нийгмийн халамжийн

дэмжлэг, туслалцаа зайлшгүй шаардлагатай өрхийн гишүүн-иргэнд тэтгэмж олгох тухай журмын 5.1.3, 5.1.4-т заасны дагуу өрхийн амьжиргааны түшингийн үнэлгээг дахин нягтлах ажиллагаанд оролцох”, 4.2.6-д “Үйл ажиллагаагаа суманд иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд, хороонд иргэдийн Нийтийн Хуралд жил тутам, сум, хорооны Засаг дарга болон аймаг, дүүргийн нийгмийн халамжийн үйлчилгээний байгууллагад улирал тутам тайлагнах. Тайланд гишүүдийн хурлын ирц, оролцоо, энэхүү дүрмийн 1.2-т заасан өрх, иргэний амьдралын нөхцөлийг судлах ажилд биечлэн оролцсон байдал зэргийг тодорхой тусгах” гэсэн заалтуудыг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээний сургалт, зөвлөгөө, сэргээн засах эмчилгээ, өдрийн үйлчилгээнд хамрагдах иргэдийг амьжиргаа дэмжих зөвлөлөөр хэлэлцүүлж аймгийн Хөдөлмөр, Халамжийн үйлчилгээний газарт хүргүүлж ажиллаагүй байна.

Энэ нь Нийгмийн хамгаалал, Хөдөлмөрийн сайдын 2012 оны А/89 дугаартай Дүрэм батлах, урамшууллын хэмжээ тогтоох тухай тушаалын хавсралт “Амьжиргааг дэмжих зөвлөлийн дүрэм”-ийн 1.2-т “Зөвлөл нь Нийгмийн халамжийн тухай хуулийн 18.1-д заасан үйлчилгээ,хамрагдах хүсэлт гаргасан өрх, иргэний баримт бичиг, амьдралын нөхцөлийг нь судлан үзэж, тэдгээрийг холбогдох нийгмийн халамжийн үйл ажиллагаанд хамруулах эсэхийг хэлэлцэн шийдвэрлэнэ.” гэсэн заалттай нийцэхгүй байна.

Сургалт, зөвлөгөө, сэргээн засах эмчилгээ, өдрийн үйлчилгээнд хамрагдах иргэдийн эрэлт бодит хэрэгцээг тодорхойлохгүй төлөвлөгөөг Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар баталж байна.

Нийгмийн хамгаалал, Хөдөлмөрийн сайдын 2012 оны А/89 дүгээр тушаалаар амьжиргаа дэмжих зөвлөлийн гишүүнд болон сум хорооны нийгмийн ажилтанд улиралд нэг удаа олгох урамшууллын хэмжээг 48.0 мянган төгрөгөөр тогтоосон байна. Энэ дүн шинэчлэгдээгүй 10 жил болсон байна.

2.2.2 Олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээг шалгуур хангасан иргэнд үзүүлээгүй байна.

Нийгмийн халамжийн тухай хуульд зааснаар нийгмийн халамжийн үйл ажиллагаа нь нийгмийн халамжийн тэтгэвэр, нийгмийн халамжийн тэтгэмж, нийгмийн халамжийн үйлчилгээ, нийгмийн хөгжлийн үйлчилгээ гэсэн 4 төрөлтэй байна.

Нийгмийн халамжийн тухай хуулийн 12 дугаар зүйлд нийгмийн халамжийн тэтгэвэр, 13 дугаар зүйлд нийгмийн халамжийн тэтгэмж, 17 дугаар зүйлд нийгмийн халамжийн үйлчилгээ, 20-р зүйлд боловсролыг дэмжих үйлчилгээ, 21-р зүйлд эрүүл мэндийг дэмжих үйлчилгээ, 22-р зүйлд хүнс тэжээлийн дэмжлэг үзүүлэх үйлчилгээнд хамрагдах өрх иргэнд тавигдах шалгуур, шаардлагыг тусгаж өгсөн байна.

Нийгмийн халамжийн үйлчилгээний төрөл, хамрагдахад тавигдах шалгуур дараах байдалтай байна.

Хүснэгт 6

№	Нийгмийн халамжийн үйл ажиллагаа	Төрөл, шалгуур, шаардлага
1	Тэтгэвэр	Нийгмийн даатгалын тухай хууль тогтоомжид заасны дагуу бүрэн болон хувь тэнцүүлэн тогтоосон тэтгэвэр авах эрх үүсээгүй дараах иргэнд 1. 60 ба түүнээс дээш настай эрэгтэй, 55 ба түүнээс дээш настай эмэгтэй, 2. 16 насанд хүрсэн одой иргэн, 3. Хөдөлмөрийн чадвараа 50 ба түүнээс дээш хувиар алдсан 16 насанд хүрсэн хөгжлийн бэрхшээлтэй иргэн, 4. Тэжээгч нь нас барсан 18 хүртэлх насны хүүхэд

		5. 18 хүртэлх насны 4 ба түүнээс дээш хүүхэдтэй, өрх толгойлсон 45 насанд хүрсэн эх, 50 насанд хүрсэн эцэг
2	Тэтгэмж	Асаргааны тэтгэмж: 1. Бүтэн өнчин хүүхдийг үрчлэн авсан болон эрсдэлд нөхцөлд байгаа хүүхдийг асран хамгаалж, харгалзан дэмжиж байгаа иргэн 2. Гэр бүлийн тухай хуулийн 25.5-д заасан болон хүчирхийллийн улмаас сэтгэл санааны болон бие махбодын хохирол хүлээж хамгаалалт шаардлагатай болсон хүүхдийг Гэр бүлийн тухай хуулийн 74 дүгээр зүйлд заасны дагуу гэр бүлдээ авч асрамжилж байгаа хүүхдийн аюулгүй байдлыг хангах зорилгоор Хүүхэд хамгааллын тухай хуулийн 13 дугаар зүйлд заасны дагуу хүүхэд асрах хувилбарт үйлчилгээнд хамрагдсан байгаа; 3. Тэжээн тэтгэх хүүхэдгүй, ганц бие ахмад настан болон хөгжлийн бэрхшээлтэй ганц бие иргэнийг гэр бүлдээ авч асрамжилж байгаа иргэн 4. Эмнэлгийн хяналтад байдаг, байнгын асаргаа шаардлагатай ахмад настан болон хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд ба иргэнийг асарч байгаа иргэн Нийгмийн халамжийн дэмжлэг, туслалцаа зайлшгүй шаардлагатай өрхийн гишүүн-иргэний тэтгэмж: 1. Үндэсний статистикийн хороо, нийгмийн халамжийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага хамтран баталсан аргачлалын дагуу өрхийн мэдээллийн нэгдсэн санд орсон, амьжиргааны түвшин нь тухайн үеийн ядуурлын шугамаас доогуур өрхөөс сонгогдсон өрхийн гишүүн 2. Нийгмийн халамжийн дэмжлэг, туслалцаа зайлшгүй шаардлагатай өрхийн гишүүн-иргэнд тэтгэмж олгох нөхцөл, болзлыг Засгийн газраас баталсан журмаар зохицуулна. Онцгой тохиолдлын болон амьжиргааг дэмжих мөнгөн тэтгэмж: 1. Гэнэтийн аюул, осол, урьдчилан төсөөлөх боломжгүй бусад шалтгаанаар гэр оронгүй, гэр орон нь цаашид амьдрах боломжгүй болсон болон амьжиргааны эх үүсвэрээ алдсан өрх 2. 18 нас хүрээгүй байхдаа бүтэн өнчин болсон 18-24 насны иргэн 3. Хорих ангиас суллагдсан өөрийн гэсэн гэр оронгүй, нийгмийн халамжийн дэмжлэг, туслалцаа зайлшгүй шаардлагатай өрхийн гишүүн-иргэн 4. Нийгмийн халамжийн дэмжлэг, туслалцаа зайлшгүй шаардлагатай, дөрөв ба түүнээс дээш 18 хүртэлх насны хүүхэдтэй, гэр оронгүй, өрх толгойлсон эцэг, эх 5. Байнгын асаргаа шаардлагатай 16 хүртэл насны хүүхдэд Засгийн газраас тогтоосон тухайн үеийн нийгмийн халамжийн тэтгэвэртэй тэнцүү хэмжээний тусламж 6. Байнгын асаргаа шаардлагатай 16 ба түүнээс дээш насны иргэн
3	Нийгмийн халамжийн үйлчилгээ	Олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээ 1. Амьдралын итгэл үнэмшил, бие даан амьдрах чадвар, хөдөлмөрийн дадал олгох, авьяасыг нь дэмжих зорилгоор сургалт зохион байгуулах 2. Зөвлөгөө өгөх 3. Сэргээн засах үйлчилгээнд хамруулах; 4. Түр байрлуулан асрамжлах, хүчирхийлэлд өртсөн хүнийг түр хамгаалан байрлуулах; 5. Өдрийн үйлчилгээнд хамруулах; 6. Гэрийн асрамж, халамжийн үйлчилгээнд хамруулах; 7. Иргэн, түүний гэр бүлийн хэрэгцээнд тулгуурласан нийгмийн халамжийн бусад үйлчилгээ үзүүлэх;

		8. Гэр оронгүй иргэн, түүний гэр бүлийн гишүүдийн амьдрах итгэлийг нэмэгдүүлэх, нийгэмшүүлэх, бичиг баримтжуулах, түр хоноглох байранд байрлуулах; 9. Нийгмийн халамжийн дэмжлэг, туслалцаа зайлшгүй шаардлагатай энэ хуулийн 3.1.2, 18.2-т заасан өрх, иргэнийг нийгэмшүүлэх, хамт олны бүлэг бүрдүүлэх, орлогын эх үүсвэртэй болгох төсөл хэрэгжүүлэх, амьдрах ухаанд сургах. 10. Нийгмийн халамжийн дэмжлэг, туслалцаа зайлшгүй шаардлагатай энэ хуулийн 3.1.2, 18.2-т заасан өрх, иргэнийг нийгэмшүүлэх, хамт олны бүлэг бүрдүүлэх, орлогын эх үүсвэртэй болгох төсөл хэрэгжүүлэх, амьдрах ухаанд сургах гэсэн төрлүүдтэй бөгөөд дараах иргэд хамрагдана. Үүнд: - Хүчирхийлэлд өртсөн иргэн - Хорих ангиас суллагдсан иргэн - Согтууруулах, мансуурах донтой өвчтэй иргэн - Эдгэшгүй хүнд өвчтэй хүн - Гэр оронгүй тэнэмэл амьдралтай өрх, иргэн - Өрх толгойлсон эх /эцэг/ - Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй өрх - Гурав болон түүнээс дээш хүүхэдтэй өрх толгойлсон эх, эцгийн хүүхэд Төрөлжсөн асрамжийн үйлчилгээ - Ахмад настны асрамжийн үйлчилгээ; - Хөгжлийн бэрхшээлтэй иргэний асрамжийн үйлчилгээ; - Хүнд нөхцөлд байгаа 18 хүртэлх насны хүүхдийн асрамжийн үйлчилгээ; - Гурав ба түүнээс дээш ихэр хүүхдийн асрамжийн үйлчилгээ гэсэн төрөлтэй бөгөөд дараах иргэд харагдана. Үүнд: - Тэжээн тэтгэх хүүхэдгүй, бие даан амьдрах чадваргүй ганц бие, эсхүл тэжээн тэтгэх хүүхэд нь ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэйн улмаас дэмжлэг, туслалцаа үзүүлэх чадваргүй, тэжээн тэтгэх үүрэгтэй этгээд нь тухайн ахмад настны эсрэг хүчирхийлэл үйлдсэн болох нь тогтоогдсон бөгөөд олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээнд хамрагдах боломжгүй ахмад настан; - Мэргэжлийн үйлчилгээ, тусгай нөхцөл шаардагдсан болон тэжээн тэтгэх хүүхэдгүй, бие даан амьдрах чадваргүй ганц бие хөгжлийн бэрхшээлтэй иргэн - Хүнд нөхцөлд байгаа, Гэр бүлийн тухай хуулийн 25.5-д заасан болон байнгын асрамжид байдаг хөгжлийн бэрхшээлтэй 18 хүртэлх насны хүүхэд - Улсын зардлаар төрөлжсөн асрамжийн газар асрамжлан өсгөхийг эцэг, эх нь зөвшөөрсөн дөрөв хүртэлх насны гурав ба түүнээс дээш ихэр хүүхэд.
4	Нийгмийн үйлчилгээ	хөгжлийн 1. Боловсролыг дэмжих үйлчилгээг дор дурдсан хүүхэд сургуулийн өмнөх боловсролын болон ерөнхий боловсролын сургуульд сурч байгаа бол хичээлийн хэрэгсэл, сурах бичиг, дүрэмт хувцасны үнийн хөнгөлөлт үзүүлэх хэлбэрээр үзүүлдэг. Үүнд: - Нийгмийн халамжийн дэмжлэг, туслалцаа зайлшгүй шаардлагатай өрхийн гишүүн-иргэний болон хөгжлийн бэрхшээлтэй иргэний хүүхэд; - Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд; - Бүтэн ба хагас өнчин хүүхэд; - Гэр оронгүй тэнэмэл амьдралтай иргэний хүүхэд; - Төрөлжсөн асрамжийн үйлчилгээнд хамрагдаж байгаа хүүхэд;

	- Хорих ангиас суллагдсан хүүхэд. - Өрхийн амьжиргааны түвшин босго шугамаас доогуур байгаа өрх толгойлсон эх, эцгийн хүүхэд
	2. Эрүүл мэндийг дэмжих үйлчилгээ - Нийгмийн халамжийн дэмжлэг, туслалцаа зайлшгүй шаардлагатай өрхийн гишүүн-иргэний эрүүл мэндийн даатгалын шимтгэлийг бүрэн болон хэсэгчлэн төлөх - Нийгмийн халамжид хамрагдагсдад үзүүлэх эрүүл мэндийн бусад үйлчилгээ
	3. Хүнс тэжээлийн дэмжлэг үзүүлэх үйлчилгээ - Нийгмийн халамжийн дэмжлэг, туслалцаа зайлшгүй шаардлагатай өрхийн гишүүн-иргэдийн дотроос нийгмийн халамжийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын тодорхойлсон хүнсний хангамж зайлшгүй шаардлагатай өрхийн гишүүн-иргэн - Гэр оронгүй, тэнэмэл амьдралтай иргэн

Эх сурвалж: Хууль, журам, ХХҮГ

Нийгмийн халамжийн тэтгэвэрт нийт хамрагдаж байгаа иргэдийн 70-75 хувийг хөдөлмөрийн чадвараа 50 ба түүнээс дээш хувиар алдсан 16 насанд хүрсэн хөгжлийн бэрхшээлтэй иргэд, 20-25 хувийг тэжээгч нь нас барсан гэр бүлийн 18 хүртэлх насны хүүхэд, 5 хувийг өндөр насны тэтгэвэр тогтоолгосон иргэд тус тус эзэлж байна. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн тэтгэврийг эмнэлэг хөдөлмөрийн магадлах комиссын шийдвэрийг үндэслэн программд эхлэх, дуусах огноог оруулдаг бөгөөд хугацаа дуусмагц автоматаар зогсдог байна.

Нийгмийн халамжийн сангаас олгож байгаа 5 нэр төрлийн халамжийн тэтгэвэр, 12 нэр төрлийн халамжийн тэтгэмж, 5 төрлийн үйлчилгээнээс нэг удаагийн шинжтэй гардаг олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээ болон онцгой тохиолдлын мөнгөн тэтгэмжийн 9 нэр төрлийн үйлчилгээг бүгдийг хамруулан харилцахын баримт, дансны хуулгыг тулган, тухайн тэтгэмж, үйлчилгээг олгоход баримтлах журамд заасан шалгуур үзүүлэлтийг хангасан эсэхийг шалгасан.

Нийгмийн халамжийн тухай хуулийн 18 дугаар зүйлд заасан 10 төрлийн олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээнээс манай аймгийн хэмжээнд сургалт зохион байгуулах, зөвлөгөө өгөх, сэргээн засах үйлчилгээнд хамруулах, төсөл хэрэгжүүлэхэд нь дэмжлэг үзүүлэх үйлчилгээнүүдийг үзүүлсэн байна.

Олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээнд 2020 онд нийт 50.3 сая төгрөгийг зарцуулснаас 16.3 сая төгрөгийн сургалт, зөвлөгөө үзүүлсэн байгууллагын тайлан хавсрагдаагүй, зөвхөн сургалт зөвлөгөө үзүүлэх төсөл, хөтөлбөрийг хавсаргасан байна.

2.2.3 Хувийн хэрэг хөтлөлт, бүрдүүлэлтийг сайжруулах шаардлагатай байна.

Иргэдийг нийгмийн халамжийн үйл ажиллагаанд хамруулахад доорх баримт материалыг цахимаар эсвэл цаасан хэлбэрээр бүрдүүлэхээр холбогдох хууль журамд заасан байна.

Нийгмийн халамжийн үйлчилгээ		Бүрдүүлэх материал															
		Өргөдөл	Байнгн Засаг даргын тодорхойлолт	2 хувь зураг	Иргэний үнэмлэхийн хуулбар	Нийтийн даатгалын сангаас тэтгэвэр авах эрх үүсвэрий тухай тодорхойлолт	Эмнэлэг, хөдөлмөрийн магадлах комиссын шийдвэр	Байнгын асрагаа шаардлагатай иргэний тодорхойлолт	Тэжээлийн нас барсны гэрчилгээ, асран хамгаалагч, харгалзан дэмжигчийн иргэний үнэмлэх, тэдгээрийн хуулбар;	Сум хорооны амьжиргааг дэмжих зөвлөлийн шийдвэр, Аймаг дүүргийн засаг даргын захирамж	Жирэмсэн үедээ эмнэлгийн хяналтад орсон тухай өрх, сум, тосгоны эрүүл мэндийн төвийн эмчийн тодорхойлолт	Хүүхэд эсэн мэнд бойжиж байгаа тухай өрх, сум, тосгоны эрүүл мэндийн төвийн эмчийн тодорхойлолт;	Хүүхдийн төрсний гэрчилгээ, хуулбарын хамт	Онцгой байдлын дүгнэлт	Одон болон гавьяа шагналын үнэмлэхийн хуулбар	Гэр бүлийн багалгаа буюу шүүхийн шийдвэр /шаардлагатай тохиолдолд/	Мөнгө төлсөн баримт
Тэтгэвэр	Эрэгтэй 60, эмэгтэй 55 болон түүнээс дээш настан иргэн	1	1	1	1	1											
	16 насанд хүрсэн одой иргэн	1	1	1	1	1	1										
	Хөдөлмөрийн чадвараа 50 ба түүнээс дээш хувиар алдсан 16 насанд хүрсэн ХБИ	1	1	1	1	1	1		1	1							
	Тэжээгч нь нас барсан 18 хүртэлх насны хүүхэд	1	1	1	1				1	1							
	18 хүртэлх насны 4 ба түүнээс дээш хүүхэдтэй, өрх толгойлсон 45 насанд хүрсэн эх, 50 насанд хүрсэн эцэг	1	1	1	1				1	1							
Асрагааны тэтгэмж	Бүтэн өнчин хүүхдийг үрчлэн авсан болон эрсдэлд нөхцөлд байгаа хүүхдийг асран хамгаалж, харгалзан дэмжиж байгаа иргэн	1	1	1	1			1									
	Хүүхэд асрах хувилбарт үйлчилгээнд хамрагдсан байгаа;	1	1	1	1			1									
	Тэжээн тэтгэх хүүхэдгүй, ганц бие ахмад настан болон хөгжлийн бэрхшээлтэй ганц бие иргэнийг гэр бүлдээ авч асрамжилж байгаа;	1	1	1	1			1									
	Эмнэлгийн хяналтад байдаг, байнгын асрагаа шаардлагатай ахмад настан болон хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд ба иргэнийг асарч байгаа.	1	1	1	1			1									
Онцгой тохиолдлын болон амьжиргааг дэмжих мөнгөн тэтгэмж	Гэнэтийн аюул, осол, урьдчилан төсөөлөх боломжгүй бусад шалтгаанаар гэр оронгүй, гэр орон нь цаашид амьдрах боломжгүй болсон болон амьжиргааны эх үүсвэрээ алдсан өрх	1	1		1					1							
	18 нас хүрээгүй байхдаа бүтэн өнчин болсон 18-24 насны иргэн	1	1		1					1					1		
	Хорих ангиас суллагдсан өөрийн гэсэн гэр оронгүй, нийгмийн халамжийн дэмжлэг, тусалцаа зайлшгүй шаардлагатай өрхийн гишүүн-иргэн;	1	1		1					1					1		
	Нийгмийн халамжийн дэмжлэг, тусалцаа зайлшгүй шаардлагатай, дөрөв ба түүнээс дээш 18 хүртэлх насны хүүхэдтэй, гэр оронгүй, өрх толгойлсон эцэг, эх	1	1		1					1					1		
АДНМТ Байнгын асрагаа шаардлагатай 16 хүртэлх насны хүүхэд		1	1	1	1												
АДНМТ Байнгын асрагаа шаардлагатай 16 ба түүнээс дээш насны иргэн		1	1	1	1												
Эхийн зэргийн I, II зэргийн одонтой эхэд олгох мөнгөн тусламж		1	1	1	1										1		
Олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээ		1	1		1												
Төрөлжсөн асрамжийн үйлчилгээ		1	1	1	1												
Нийгмийн хөгжлийн үйлчилгээ		1	1		1												
Эх, олон хүүхэдтэй өрх толгойлсон эх, эцэгт олгох тэтгэмж	Жирэмсэн эхийн тэтгэмж;	1	1	1	1						1						
	0-3 хүртэлх насны хүүхэд асарсны тэтгэмж	1	1	1	1							1	1				
	Ихэр хүүхдийн тэтгэмж	1	1		1							1	1				
	Гурав болон түүнээс дээш хүүхэдтэй өрх толгойлсон эх, эцгийн тэтгэмж	1	1	1	1							1	1			1	
Протезийн төрлүүд		1	1		1		1										1
Ортопедийн хэрэгсэл		1	1		1		1										1
Тусгай хэрэгсэл		1	1	1	1		1										1
Ахмад настанд олгох хөнгөлөлт, тусламж		1	1		1		1			1							1
Хөгжлийн бэрхшээлтэй иргэнд олгох хөнгөлөлт, тусламж		1	1		1		1			1							1

Эх сурвалж: Хууль, журам, ХХҮГ

Нийгмийн халамжийн тухай хуулийн 22.2.1-д заасан хүнсний бүтээгдэхүүн эсхүл хүнсний бүтээгдэхүүн худалдан авах эрхийн бичиг олгох үйлчилгээг авч байгаа иргэдийн хувийн хэргээс Хэрлэн сумын 1, 5, 7, 8-р багийн нийт 424 өрхийн хувийн хэргийг түүвэрлэн шалгахад хувийн хэргийн бүрдэл хангалтгүй байна. Үүнд өрхийн гишүүдийн мэдээллийг бүртгээгүй 235 өрх буюу нийт түүврийн 55.4 хувь, хүнсний эрхийн бичиг олгосон тэмдэглэл хөтлөөгүй нь 372 өрх буюу нийт түүврийн 87.7 хувийг эзэлж байна. Хэрлэн сумын хэмжээнд нийт 1435 өрх хүнсний эрхийн бичгийн үйлчилгээг авч байгаагаас 16 өрх нь хувийн хэрэггүй байна.

Олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээ үзүүлэх журмын 2.6."Аймаг, дүүргийн нийгмийн халамжийн үйлчилгээний байгууллага нь энэхүү журмын 2.3-т заасан шийдвэр, баримт бичгийг ажлын 5 хоногт багтаан хянан үзэж, үйлчилгээнд хамрагдах өрх, иргэнд хувийн хэрэг нээн баталгаажуулж, сум, хорооны нийгмийн ажилтанд хүргүүлнэ." гэсэн заалтын дагуу Олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээнд хамрагдсан иргэнд хувийн хэрэгтэй байхаар журамд заасан байхад хувийн хэрэг нээж ажиллаагүй байна.

2.2.4 Халамжийн үйлчилгээг үзүүлэхдээ давхцалыг тооцож үздэггүй байна.

Дорнод аймгийн хэмжээнд Нийгмийн халамжийн үйлчилгээнд хамрагдсан нийт иргэдийн мэдээллийг программаас татан үзэхэд 2020-2021 онд 3-4 төрлийн халамж авсан 4291 иргэн, 5-7 төрлийн халамж авсан 1838 иргэн, 8-10 төрлийн халамж авсан 239 иргэн, 11-13 төрлийн халамж авсан 34 иргэн, 14-15 төрлийн халамж авсан 3 иргэн байна.

Үүнээс түүвэрлэн зорилтот бүлгийн хөдөлмөр эрхэлдэггүй 50 өрхийн нийгмийн халамжийн үйлчилгээнд хамрагдсан мэдээллийг шүүхэд 947.1 мянган төгрөгөөс 1,249.2 мянган төгрөгийн халамжийн үйлчилгээ авч байгаа 6 өрх, 420.5 мянган төгрөгөөс 799.1 мянган төгрөгийн халамжийн үйлчилгээ авдаг 19 өрх байна. Эдгээр өрхийн орлого нь хүүхдийн мөнгө, асаргааны тэтгэмж болон нийгмийн эмзэг бүлэгт хоол тэжээлийн дэмжлэг үзүүлэх дэд хөтөлбөрөөс бүрдэж байна.

Түүвэрт хамрагдсан 50 өрхийн 25 өрх нь буюу 50 хувь нь хөдөлмөрийн хөлсний доод хэмжээнээс илүү орлоготой байна.

Нийгмийн халамжийн тухай хууль, журам, зааварт нэг иргэн, өрх хэдэн төрлийн халамж авах талаар тодорхой хязгаар тогтоож өгөөгүй, олон нэр төрлийн үйлчилгээг давхардуулан авах боломжтой байна.

2.3 Халамжийн сангийн хөрөнгийг үр нөлөөтэй зарцуулаагүй байна.

2.3.1 Халамжийн үйлчилгээ үзүүлэх ТББ, ААН-үүдтэй гэрээ байгуулахдаа журамд заасан нөхцөлүүдийг бүрэн тусгаагүй байна.

Улсын төсвөөс санхүүжигддэг ахмадын амралт, сувилал, ахмад настан ХБИ-д тусгай хэрэгсэл нийлүүлэх аж ахуй нэгжүүдийн сонгон шалгаруулалтыг Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газарт зохион байгуулж, гэрээ байгуулж ажилладаг байна.

Орон нутгийн төсвөөс санхүүждэг Олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээний сургалт, зөвлөгөө, сэргээн засах үйлчилгээ, өдрийн үйлчилгээний төсөв нь худалдан авах ажиллагааны босго үнээс хэтэрдэггүй тул үйлчилгээ үзүүлэх ААН, ТББ-тай шууд гэрээ байгуулан ажилласан байна.

Ингэхдээ 2020 онд хоёр ТББ-тай санхүүжилтийн мөнгөн дүнгүй гэрээ байгуулж ажилласан байна. Хөдөлмөр халамжийн үйлчилгээний газрын даргын 2012 оны 164 дүгээр тушаалын хавсралтаар батлагдсан Нийгмийн асрамж, халамжийн үйлчилгээ үзүүлэх иргэн, хувийн хэвшлийн аж ахуйн нэгж, төрийн бус байгууллагатай хамтран ажиллах гэрээ байгуулах журам"-ын 3.2-т "гэрээнд дараах нөхцөлийг заавал тусгана." 3.2.3-т "Санхүүжилтийн хэмжээ" гэсэн заалтыг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Хөдөлмөр, Халамжийн үйлчилгээний газар нь 2020 онд гэрээ байгуулан халамжийн үйлчилгээг үзүүлсэн ААН, ТББ-ын гэрээг үнэлж, дүгнээгүй, мөн санхүүжилтийн хэмжээ болон ажлын календарчилсан төлөвлөгөөг тусгаагүй, 2021 онд журамд заасны дагуу гэрээний биелэлтийг оноогоор үнэлж, дүгнээгүй зэрэг нь Хөдөлмөр халамжийн үйлчилгээний газрын даргын 2012 оны 164 дүгээр тушаалын хавсралтаар батлагдсан Нийгмийн асрамж, халамжийн үйлчилгээ үзүүлэх иргэн, хувийн хэвшлийн аж ахуйн нэгж, төрийн бус байгууллагатай хамтран ажиллах гэрээ байгуулах журам"-ын 3.2-т "гэрээнд дараах нөхцөлийг заавал тусгана." ...3.2.5. Ажил гүйцэтгэх хугацаа, ажлын календарчилсан төлөвлөгөө" болон гэрээний биелэлтэд хяналт тавих дөрөвдүгээр

бүлгийн 4.2-т “Шууд гэрээ байгуулсан байгууллагын ажил, үйлчилгээний явцад тухайн нэгжийн дарга, мэргэжилтэн болон Хяналт, шинжилгээ, үнэлгээ хариуцсан нэгжийн дарга, мэргэжилтэн тус тус хяналт тавьж ажиллана. Үүнд 4.2.1.Ажил, үйлчилгээний явц, 4.2.2.Хөрөнгийн зарцуулалт, 4.2.3.Стандартын хэрэгжилт”-д тус тус хяналт тавьж ажилласан баримт байхгүй байна. Харин 2020 онд нэг удаа Хөдөлмөр, Халамжийн үйлчилгээний газраас баталсан удирдамжийн дагуу хяналт тавьж ажилласан байна.

2.3.2 Халамжийн сангийн хөрөнгийг нарийн шалгуур үзүүлэлтгүй хавтгайруулан олгож байна.

Нийгмийн халамжийн сангийн үйлчилгээнд давхардсан тоогоор 2020 онд нийт 78.7 мянган иргэнд 43.3 тэрбум төгрөг, 2021 онд 76.0 мянган иргэнд 52.6 тэрбум төгрөгийг зарцуулсан байна.

Нийгмийн халамжийн үйлчилгээ авах шаардлагагүй дундаж болон дунджаас дээгүүр амьдралтай иргэд халамжийн үйлчилгээнд хамрагдах боломжтой байна. Үүнд: Хүүхдийн мөнгийг өрх бүр, жирэмсэн эхийн тэтгэмж, цалинтай ээж хөтөлбөрт хүүхэдтэй болсон бүх эмэгтэйчүүд, мөн 0-18 нас хүртэлх насны гурав болон түүнээс дээш хүүхэдтэй өрх толгойлсон эх, эцэг хамрагдаж байна.

Энэ нь нийт халамжийн сангийн 2020 оны төсвийн 69.0 хувийг, 2021 оны төсвийн 76.7 хувийг тус тус эзэлж байна.

Халамжийн сангийн үйлчилгээнээс зарим үйлчилгээнд хөдөлмөр эрхэлдэг эсэх гэсэн шалгуур тавьж нийтээр хавтгайруулан олгохоос татгалзах шаардлагатай байна.

Эмнэлэг, хөдөлмөрийн магадлах комиссын дүгнэлтээр хөдөлмөрийн чадвар алдалтын хувь тогтоолгосон хөгжлийн бэрхшээлтэй хүн Улсын хэмжээнд 2021 онд 105.6 мянга байжээ. Энэ нь хүн амын тоотой харьцуулахад 3.2 хувийг эзэлж байгаа бол Дорнод аймгийн хэмжээнд 2021 онд 4192 хүн буюу нийт хүн амын 5.0 хувь байгаа нь улсын дунджаас өндөр байна.

Хүснэгт 8

2020	Аймаг	Хүн ам	ХБИ	Хувь	2021	Аймаг	Хүн ам	ХБИ	Хувь
1	Увс	83,524	4629	5.54	1	Увс	84,095	4715	5.61
2	Говь-Алтай	57,674	3116	5.40	2	Говь-Алтай	57,818	2970	5.14
3	Дорнод	83,087	4269	5.14	3	Дорнод	83,757	4192	5.00
4	Завхан	72,763	3721	5.11	4	Завхан	72,731	3509	4.82
5	Сэлэнгэ	109,285	4980	4.56	5	Сэлэнгэ	108,878	5106	4.69
6	Хөвсгөл	135,705	6023	4.44	6	Хөвсгөл	136,794	5926	4.33
7	Сүхбаатар	63,822	2707	4.24	7	Сүхбаатар	64,662	2707	4.19
8	Дархан-Уул	106,909	4474	4.18	8	Дархан-Уул	107,751	4276	3.97
9	Говьсүмбэр	17,965	748	4.16	9	Говьсүмбэр	18,150	711	3.92
10	Орхон	107,765	4264	3.96	10	Дундговь	46,920	1827	3.89
11	Дундговь	46,981	1851	3.94	11	Орхон	108,713	4216	3.88
12	Архангай	94,088	3669	3.90	12	Булган	61,943	2398	3.87
13	Хэнтий	78,172	3022	3.87	13	Дорноговь	71,457	2747	3.84
14	Баянхонгор	88,955	3432	3.86	14	Архангай	94,205	3597	3.82
15	Баян-Өлгий	110,597	4245	3.84	15	Хэнтий	78,967	2924	3.70
16	Дорноговь	71,207	2720	3.82	16	Баянхонгор	89,043	3279	3.68
17	Булган	61,955	2356	3.80	17	Өвөрхангай	115,732	4077	3.52
18	Өвөрхангай	115,732	4259	3.68	18	Баян-Өлгий	112,836	3851	3.41
19	Төв	93,162	3303	3.55	19	Төв	93,468	3065	3.28
20	Ховд	90,533	2866	3.17	20	Өмнөговь	71,720	2211	3.08

21	Өмнөговь	70,371	2189	3.11	21	Ховд	91,127	2699	2.96
----	----------	--------	------	------	----	------	--------	------	------

Эх сурвалж: www.1212.mn

Эмнэлэг, хөдөлмөрийн магадлах комиссын дүгнэлтээр хөдөлмөрийн чадвар алдалтын хувь тогтоолгож ХБИ тэтгэмж авах иргэд нэмэгдэж байгаа тул дахин магадлалыг эмнэлэг, хөдөлмөрийн магадлах төв комиссоор хийлгэх шаардлагатай байна.

Эрүүл мэндийн сайд, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2021 оны 12 сарын 28-ны өдрийн А/807, А/216 дугаар хамтарсан тушаалын хавсралтаар асруулагч нь шалгуур үзүүлэлтүүдээр үнэлүүлж 0-6 оноо авсан тохиолдолд асаргаа авдаг байна.

Дорнод аймгийн хэмжээнд 2022 оны 6 сарын байдлаар 1206 иргэн ахмад настан болон хөгжлийн бэрхшээлтэй иргэн, хүүхэд асарч, асаргааны тэтгэмж авч байна. Эмчийн хяналтад байдаг ахмад настан, ХБИ-ийг асардаг иргэн сард 84.5 мянган төгрөг, эмчийн хяналтад байдаг хөгжлийн бэрхшээлтэй 16 хүртэлх насны хүүхдээ асарч байгаа иргэнд 123.1 мянган төгрөг авч байна.

Асаргааны тэтгэмж авч байгаа 1206 иргэний 398 нь буюу 33.0 хувь нь хөдөлмөр эрхэлж нийгмийн даатгалын шимтгэл төлсөн байна.

2.3.3 Олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээнд орон нутгийн төсвөөс баталсан хөрөнгө зорилтод бүлэгтээ хүрээгүй байна.

Олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээ, онцгой тохиолдлын мөнгөн тэтгэмжийг орон нутгийн төсвөөс санхүүжүүлж байна.

Олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээнд 2020 онд 35.4 сая төгрөг, 2021 онд 50.6 сая төгрөг, 2022 онд 62.8 сая төгрөг тус тус батлагдсан байна. Гүйцэтгэлээр 2020 онд онцгой тохиолдлын мөнгөн тэтгэмжийн хэмнэлтээр төсвөө нэмэгдүүлснээр 15.0 хувиар хэтрүүлж, 2021 онд 92.0 хувиар, 2022.06 сарын байдлаар 5.2 хувийн гүйцэтгэлтэй ажиллаж байна.

Сургалт, зөвлөгөө, сэргээн засах үйлчилгээ, өдрийн үйлчилгээ үзүүлэх ААН, ТББ-тай гэрээ байгуулж гүйцэтгүүлж ажилладаг байна.

Сургалт, зөвлөгөө, сэргээн засах үйлчилгээ, өдрийн үйлчилгээ авах иргэдийн тоо, мэдээллийг сум хорооны амьжиргаа дэмжих зөвлөлөөс ирүүлдэггүй, үйлчилгээг үзүүлэх ААН, ТББ-ууд өөрсдөө үйлчлүүлэгчээ олж материалыг нь ХХҮГ-т хүргүүлж ажилладаг байна. Халамжийн үйлчилгээ үзүүлэх ТББ-ууд, ААН-үүд чанаргүй, эрэлтэд суурилагагүй сургалт, зөвлөгөө, сэргээн засах эмчилгээ үзүүлж байна.

Энэ нь олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээнд хамрагдах иргэдийн эрэлтийг тодорхойлж ажилладаггүй байна. Мөн ААН, ТББ-уудын үйл ажиллагааны тайланд олон хүнд хүрч үйлчилж байгаа юм шиг боловч 5-7 хоногийн сургалт, зөвлөгөө, сэргээн засах, өдрийн үйлчилгээнд хамрагдсанаар ямар өөрчлөлт ахиц гарсан эсэх нь тодорхойгүй, ХХҮГ-аас үйлчилгээнд хамрагдсан иргэдэд гарсан өөрчлөлтийг тооцож ажлыг үнэлж ажилладаггүй байна.

ААН, ТББ-уудын хөрөнгийн зарцуулалт, үйлчилгээний явц, стандартын хэрэгжилтэд хийх хяналтыг ХХҮГ нь 2021 онд хэрэгжүүлээгүй байна.

Нийгмийн халамжийн дэмжлэг, туслалцаа зайлшгүй шаардлагатай Нийгмийн халамжийн тухай хуулийн 3.1.2, 18.2-т заасан өрх, иргэнийг нийгэмшүүлэх, хамт олны бүлэг бүрдүүлэх, орлогын эх үүсвэртэй болгох төсөл хэрэгжүүлэх, амьдрах ухаанд сургах үйлчилгээнд 2020 онд 20 бүлэгт 25.0 сая төгрөг, 2021 онд 27 бүлэгт 33.5 сая төгрөгийг зарцуулсан байна. Бүлгийн төсөлд хамрагдсан иргэдээс

түүвэрлэн шалгахад мөнгө аваагүй, төслийн талаар мэдээлэл байхгүй, төсөл хэрэгжүүлээгүй зэрэг асуудлууд илэрсэн тул гэмт хэргийн шинжтэй байж болзошгүй гэж үзэн Төрийн аудитын тухай хуульд заасны дагуу Прокурорын байгууллагад шилжүүлсэн.

Онцгой тохиолдлын мөнгөн тэтгэмжээр буцалтгүй 1.2 сая төгрөгийг гэнэтийн аюул осол, урьдчилан төсөөлөх боломжгүй бусад шалтгаанаар гэр оронгүй, гэр орон нь цаашид амьдрах боломжгүй болсон болон амьжиргааны эх үүсвэрээ алдсан өрх, хорих ангиас суллагдсан иргэн, 18 нас хүрээгүй байхдаа бүтэн өнчин болсон иргэн, нийгмийн халамжийн дэмжлэг туслалцаа зайлшгүй шаардлагатай 4 ба түүнээс дээш 18 нас хүрээгүй өрх толгойлсон эцэг, эхэд сум хорооны засаг даргын тодорхойлолт, онцгой байдлын дүгнэлт, амьжиргааг дэмжих зөвлөлийн шийдвэр, ял шийтгэл эдэлж байгаад суллагдсан тодорхойлолт зэргийг үндэслэж 2020 онд 83 иргэнд 99.6 сая төгрөгийг, 2021 онд 69 иргэнд 82.8 сая төгрөгийг, 2022.06 сарын байдлаар 17 иргэнд 20.4 сая төгрөгийг тус тус олгосон байна.

2.4 Хүнс тэжээлийн дэмжлэг олгох үйлчилгээг үр нөлөөтэй хэрэгжүүлээгүй байна.


2.4.1 Хүнсний эрхийн бичгийг эрх бүхий итгэмжлэгдсэн төлөөлөлд журмын дагуу олгосон байна.

Хүнсний эрхийн бичгийг 2020 онд сумын төвөөс алслагдсан малчин бүхийн 47 өрх итгэмжлэгдсэн хүнээр дамжуулан авсан байна. Эдгээр 47 хүнд журмын дагуу олгосон эсэхийг шалгахад зөрчил илрээгүй. Хүнс тэжээлийн дэмжлэг үзүүлэх үйлчилгээ 2021 оноос цахимд шилжсэн байна. НӨАТ-ын баримт олгодог хүнсний дэлгүүрээр үйлчлүүлэх боломжийг нээж, иргэдийн дансанд мөнгө шилжүүлдэг болсон байна. Хүнс тэжээлийн дэмжлэг үзүүлэх үйлчилгээнд хамрагдсан иргэд цахим карт ашиглан шалгуур хангасан дэлгүүрүүдээс үйлчилгээ авдаг болсон байна.

2.4.2 “Хүнсний эрхийн бичиг олгох журам”-ын 1.4, 1.5 -д заасан нөхцөлийг хангаагүй өрх, иргэнээс хасалт хийгдээгүй байна.

Хөдөлмөр, Халамжийн үйлчилгээний ерөнхий газрын 2021 оны 9 дүгээр сарын 30-ны өдрийн 7/1137 тоот албан бичгээр өгсөн чиглэлийн дагуу хүнсний эрхийн бичгийн үйлчилгээнд хамрагддаг иргэдийн мэдээллийг дахин нягталж 2021 онд 181 өрхийн 990 иргэн, 2022 оны 6 сарын байдлаар 398 өрхөөс 2535 иргэний хасалт хийгдсэн байна.

Дүрслэл 1



Эх сурвалж: 1212.mn, Дорнод аймгийн ХХҮГ-ын төсвийн гүйцэтгэлийн мэдээ.

Хүснэгт 9

№	СУМ НЭР	2020		2021		2022		Өрхийн өсөлт + /бууралт -		Өрхийн гишүүний өсөлт + /бууралт -	
		Өрх	Иргэн	Өрх	Иргэн	Өрх	Иргэн	2021 он	2022 он	2021 он	2022 он
1	Баяндун сум	56	319	49	281	42	240	-7	-7	-38	-41
2	Баянтүмэн сум	59	347	48	281	32	185	-11	-16	-66	-96
3	Баян-Уул сум	59	348	37	217	17	90	-22	-20	-131	-127
4	Булган сум	9	41	9	41	7	31	0	-2	0	-10
5	Гурванзагал сум	26	153	18	98	14	76	-8	-4	-55	-22
6	Дашбалбар сум	31	182	14	84	9	52	-17	-5	-98	-32
7	Матад сум	66	340	47	252	41	217	-19	-6	-88	-35
8	Сэргэлэн сум	46	235	44	222	33	163	-2	-11	-13	-59
9	Халх гол сум	47	267	38	214	33	182	-9	-5	-53	-32
10	Хөлөнбуйр сум	29	163	17	94	16	88	-12	-1	-69	-6
11	Хэрлэн сум	1763	9911	1726	9801	1435	7903	-37	-291	-110	-1898
12	Цагаан-Овоо сум	86	485	71	362	47	217	-15	-24	-123	-145
13	Чойбалсан сум	24	133	15	79	13	70	-9	-2	-54	-9
14	Чулуунхороот сум	35	214	22	122	18	99	-13	-4	-92	-23
НИЙТ ДҮН		2336	13138	2155	12148	1757	9613	-181	-398	-990	-2535


Эх сурвалж: 1212.тп, Халамжийн сангийн 2020-2022 оны төсвийн гүйцэтгэлийн мэдээ.

Аудитаар хүнсний эрхийн бичгийн үйлчилгээнд хамрагддаг өрхүүдээс түүвэрлэж 165 өрхийн 953 иргэдийн хувийн хэрэг, нөхцөл байдалтай газар дээр нь очиж танилцсан. Тогтсон хаягтаа байхгүй, малчин болсон, аймаг, нийслэл рүү шилжсэн, өрх тусгаарласан, өндөр насны тэтгэвэр авч байгаа зэрэг хүнсний эрхийн бичгийн үйлчилгээнээс хасах шаардлагатай 86 өрхийн 474 иргэд байна.

Хүнсний эрхийн бичгээр үйлчлүүлж байгаа өрх иргэнд холбогдох хуульд заасны дагуу нөхцөл байдлын үнэлгээ хийж, шаардлага хангаагүй өрх иргэнийг журмын дагуу үйлчилгээнээс түдгэлзүүлэх арга хэмжээг үр дүнтэй зохион байгуулаагүй байна.

2.4.3 Хүнсний эрхийн бичгээр үйлчлэх дэлгүүрийн сонгон шалгаруулалтыг 2020 онд хуулийн дагуу зохион байгуулсан байна.

Дорнод аймгийн хэмжээнд Нийгмийн халамжийн тухай хуулийн 22.1.1-д заасан хамгийн бага орлоготой өрхийн гишүүн-иргэнд шаардлагатай хүнсний бүтээгдэхүүнээр үйлчилгээ үзүүлэх заалтыг үндэслэн Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 8.1.1 дэх заалтын дагуу Хүнсний эрхийн бичгээр иргэнд үйлчилгээ үзүүлэх 71 дэлгүүрийг 2020 онд сонгон шалгаруулсан байна.



Хүнсний эрхийн бичгийн үйлчилгээг 2020 онд 71 дэлгүүрээр дамжуулан иргэдэд үзүүлсэн байна. Сонгон шалгаруулалтыг журмын дагуу зохион байгуулсан байна.

Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2021 оны А/103 дугаар тушаалаар “Хүнсний эрхийн бичиг олгох журам” шинэчлэн батлагдаж Хүнсний эрхийн үйлчилгээг цахим картаар иргэдэд

үзүүлдэг болсон байна. Хүнсний эрхийн бичгийн үйлчилгээнд хамрагдагч иргэн цахим картаараа аль ч дэлгүүрүүдээс хүнс авах боломжтой болсон байна.

2.4.4 Хэрлэн сумын хүнсний эрхийн бичгээр үйлчилдэг дэлгүүрүүдтэй 2020 онд байгуулсан гэрээний биелэлтийг дүгнээгүй байна.


Хүнсний эрхийн бичгээр үйлчилдэг 13 сумын 24 дэлгүүрүүдтэй 2020 онд байгуулсан “Хүнсний цаасан эрхийн бичгээр хүнсний бүтээгдэхүүн олгох үйл ажиллагаанд хүнсний дэлгүүртэй хамтран ажиллах” гэрээний биелэлтийг дүгнэн ажилласан байна.

Хэрлэн сумын хүнсний эрхийн бичгээр үйлчилдэг дэлгүүрүүдийг дүгнэсэн баримт байхгүй байна. Гэрээний биелэлтийг дүгнэсэн ажлын баримтыг архивын нэгж болгон архивын ажилтанд хүлээлгэн өгсөн хадгаламжийн нэгж байхгүй байна. Мөн тайлант хугацаанд Хүнс тэжээлийн дэмжлэг тусалцаа хариуцсан мэргэжилтэн 3-4 удаа солигдсонтой холбоотой ажлын баримтыг хүлээлцэн баталгаажуулаагүй байна.

2.4.5 Хүнс тэжээлийн дэмжлэг олгох үйлчилгээний хүртээмж үр нөлөөгүй байна.

Хүнс тэжээлийн дэмжлэг авдаг нийт 9613 иргэдийн 52.4 хувь том хүн, 47.6 хувь хүүхэд эзэлж байна.

Дүрслэл 2



Эх сурвалж: 1212.тп, Халамжийн сангийн 2020-2022 оны төсвийн гүйцэтгэлийн мэдээ.

Дээрх дүрслэлээс харахад 20-29 насны 1195 иргэн, 30-39 насны 1281 иргэн, 40-49 насны 1108 иргэн байгаа бөгөөд хүнс тэжээлийн дэмжлэг авдаг иргэдийн 34.1 хувь хөдөлмөрийн насны 3278 иргэн байна. Үүнээс хөдөлмөрийн чадвартай 2605 иргэн хөдөлмөрийн хэлтэст ажил хайгчаар бүртгүүлээгүй байна.

Энэ нь "Хүнсний эрхийн бичиг олгох журам"-ын 1.3¹-д заасан хөдөлмөрийн насны, хөдөлмөрийн чадвартай боловч хөдөлмөр эрхлээгүй иргэд нь тухай журмын 1.4.1²-д заасан болзол, 1.5³-д заасан нөхцөлийг хангахгүй байна.

¹ "Тухайн өрхийн хөдөлмөрийн насны, хөдөлмөрийн чадвартай боловч хөдөлмөр эрхлээгүй гишүүнд хүнсний эрхийн бичгийг хөдөлмөр эрхлэлтийг дэмжих арга хэмжээ, үйлчилгээнд хамрагдах нөхцөлтэйгөөр олгоно"

² Энэхүү журмын 1.3-т заасан иргэн хүнсний эрхийн бичгийг авах эхний 6 сарын хугацаанд дараах болзлыг хангана", 1.4.1. ажил хайж аймаг, нийслэл, дүүргийн хөдөлмөр эрхлэлтийн байгууллагад бүртгүүлсэн"

³ 1.5. "Энэхүү журмын 1.3-т заасан иргэн хүнсний эрхийн бичигт хамрагдсан эхний 6 сараас хойш хөдөлмөр эрхлэлтийн байгууллагаас санал болгосон дараах арга хэмжээнээс 2-оос доошгүй үйл ажиллагаанд хамрагдсан тохиолдолд хүнсний эрхийн бичгийг үргэлжлүүлэн олгоно." 1.5.1. "хөдөлмөрт бэлтгэх арга хэмжээ, хөдөлмөр эрхлэлтийн сургалтад хамрагдсан байх;" 1.5.2. "хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөрүүдийн хүрээнд бий болсон түр ажлын байр болон тухайн орон нутгийн Засаг даргын захирамжаар жилдээ 2 удаа нийтийг хамарсан ажилд хамрагдсан байх;" 1.5.3. "сум, хорооны нийгмийн ажилтнаас зохион байгуулсан сургалт болон бусад үйл"

Хүнсний эрхийн бичигт хамрагдсан өрхийг шаардлага шалгуур хангасан эсэхэд ХХҮГ-аас арга хэмжээ аваагүй, хөрөнгийг арвилан хэмнэлтгүй, хавтгайруулан олгож байна.

2.4.6 Хүнс тэжээлийн дэмжлэг авсан иргэдийг журамд заасны дагуу хөдөлмөр эрхлэлтийн үйлчилгээнд хамруулах ажлыг үр дүнтэй зохион байгуулаагүй байна.

Хүнсний эрхийн бичигт хамрагддаг хөдөлмөрийн 25-54 насны 3287 иргэн байгаагаас хөдөлмөрийн чадвартай 2605 иргэнийг хөдөлмөр зуучлалд бүртгүүлж хүнсний эрхийн бичгийн үйлчилгээнээс түдгэлзүүлэх чиглэлийг баримтлан ажиллаагүй байна.

Хүнсний эрхийн бичгийн үйлчилгээ авдаг 165 өрхийн хөдөлмөрийн насны 335 иргэдийн ажил хөдөлмөр эрхэлж байгаа байдал, ажиллах хүсэл сонирхол, ажил олгогчоос тавьж байгаа шалгуур зэрэгт түүврийн аргаар нөхцөл байдлын үнэлгээ хийж үзэхэд Матад, Халхгол сумын төвд барилгын туслахын түр ажлын байранд 10 хүн, Газрын тосны туслан гүйцэтгэх компанид туслах ажилтан 50 хүнийг 1200.0 мянган төгрөгийн цалинтай ажлын байр байхад хөдөлмөрийн чадвартай иргэд, залуучууд бүртгүүлээгүй, нийтийг хамарсан ажилд хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг хамруулдаг, ХХҮГ-аас зохион байгуулдаг сургалтад хамрагдаагүй байна.

Хүнсний эрхийн бичгийн үйлчилгээнд хамрагдаг хөдөлмөрийн насны, хөдөлмөр эрхлэх чадвартай иргэдийг ажил мэргэжлийн чиг баримжаа олгох сургалтад бүрэн хамруулж, ажлын байранд зуучлах ажлыг үр дүнтэй зохион байгуулаагүй байна.

БҮЛЭГ 3. ХАЛАМЖИЙН САНГИЙН ХӨРӨНГИЙН ЗАРЦУУЛАЛТАД ТАВИХ ДОТООД ХЯНАЛТ ҮР НӨЛӨӨГҮЙ БАЙНА.

3.1 Халамжийн сангийн үйл ажиллагааны тайлан, мэдээг хугацаанд нь тайлагнасан байна.

3.1.1 Нийгмийн хөгжлийн үйлчилгээ, халамжийн үйлчилгээг хууль, журамд заасны дагуу тайлагнаж ажилласан байна.

Нийгмийн халамжийн тухай хуулийн 10 дугаар зүйлд “Халамжийн сангийн тайлан тэнцэл гаргах, тайлагнах”, 25 дугаар зүйлд “Нийгмийн халамжийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын бүрэн эрх”, 25.1.2 дахь заалт “Халамжийн сангаас тэтгэвэр, тэтгэмж олгох, нийгмийн халамжийн болон нийгмийн хөгжлийн үйлчилгээ үзүүлэх ажлыг зохион байгуулах, тайлагнах” гэж заасны дагуу Дорнод аймгийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын Нийгмийн халамжийн хэлтсийн 2020, 2021 оны жилийн эцсийн тайланд Нийгмийн хөгжлийн үйлчилгээ, халамжийн үйлчилгээ үзүүлсэн талаар тусгаж, үр дүнг тооцож тайлагнасан байна.

3.1.2 Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар нь хуулийн хэрэгжилтийг хангаж, халамжийн үйлчилгээг ил тод мэдээлж ажилласан байна.

Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн 6 дугаар зүйлд “Нийтийн мэдээлэл хариуцагч”, 6.1.1 дэх заалт “Төрийн байгууллага” гэж заасан байна. Тус хуулийн 8 дугаар зүйлд “Төрийн үйл ажиллагааг ил тод, нээлттэй байлгах, төрийн үйл ажиллагаанд олон нийтийн хяналтыг бий болгох зорилгоор мэдээлэл хариуцагчийн чиг үүрэг, үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалт, хүний нөөц, төсөв, санхүү, худалдан авах ажиллагаа, үзүүлж байгаа үйлчилгээ болон хуулиар

ажиллагаанд идэвхтэй оролцсон байх;”, 1.5.4. ажил хайгчаар бүртгүүлснээс хойш 2-оос доошгүй ажил олгогчтой уулзаж ажил идэвхтэй хайсан байх;”, 1.5.5. ажилд зуучлуулж, тогтвортой ажил хөдөлмөр эрхэлсэн байх.”

хаалттай, хязгаарлалттай гэж тогтоосноос бусад мэдээллийг ил тод, нээлттэй байлгана” гэж заасан байна. Нийгмийн халамжийн тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.7 дахь хэсэгт “Зөвлөлийн шийдвэр нь Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай хуульд зааснаас бусад тохиолдолд нийтэд нээлттэй, ил тод байна”, Засгийн газрын тусгай сангийн тухай хуулийн 24 дүгээр зүйлд “Тусгай сангийн тайлагнал, ил тод байдал” гэж заасны дагуу <https://dornod.hudulmur-halamj.gov.mn/> цахим хуудсанд Халамжийн үйлчилгээний талаар ил тод нээлттэй мэдээлж ажилласан байна. Дорнод аймгийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын фейсбүүк хуудсанд халамжийн үйлчилгээ болон үйл ажиллагааны талаар мэдээ, мэдээлэл оруулсан байна.

3.1.3 Шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд мэдээллийг байршуулахдаа хуульд заасан хугацааг хоцроон байршуулдаг зөрчил гарсаар байна.

Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.2 дахь хэсэгт “Энэ хуульд дараах төсөв, санхүүгийн үйл ажиллагааны төлөвлөлт, гүйцэтгэл, хэрэгжилт, тайлагнал эдгээртэй холбоотой мөнгөн болон бусад гүйлгээ хамаарна”, 3.2.3 дахь заалтад “Засгийн газрын тусгай сан”, Засгийн газрын тусгай сангийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.3 дахь хэсэгт “Тусгай сан дараах төрөлтэй байна”, 5.3.12 дахь заалтад “Нийгмийн халамжийн сан” гэж заасан байна. Дорнод аймгийн Халамжийн сангийн Шилэн дансны цахим хуудсанд хуульд заасан мэдээллийг байршуулсан эсэхийг шалгахад дараах зөрчлүүд илэрсэн.

- 2020 онд Шилэн дансны цахим хуудсанд байршуулбал зохих 161 мэдээллээс 107 мэдээллийг хуулийн хугацаа хоцроосон, аудитын тайлан, дүгнэлт, зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний тайланг байршуулаагүй байна.
- 2021 онд Шилэн дансны цахим хуудсанд байршуулбал зохих 161 мэдээллээс 17 мэдээллийг хуулийн хугацаа хоцроосон байна.
- 2022 онд Шилэн дансны цахим хуудсанд байршуулбал зохих 161 мэдээллээс 3 мэдээллийг хуулийн хугацаа хоцроосон, 40 мэдээллийн байршуулах хуулийн хугацаа болоогүй байна.

3.2 Халамжийн сангийн хөрөнгийн зарцуулалтад дотоод хяналт, шалгалтыг үр дүнтэй зохион байгуулаагүй байна.

3.2.1 ХХҮЕГ-аас халамжийн санд хяналт шалгалтыг зохион байгуулах талаар чиглэл өгч ажилласан байна.

ХХҮЕГ-ын 2020 оны 9 дүгээр сарын 07-ны өдрийн 9/1275 тоот “Хяналт шалгалтын ажил эрчимжүүлэх тухай” албан бичигт Нийгмийн халамжийн чиглэлээр 5 чиглэл өгч, биелэлтийг 2020 оны 10 дугаар сарын 01-ний дотор ирүүлэхээр заасан байна. Дорнод аймгийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын 2020 оны 9 дүгээр сарын 30-ны өдрийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газрын хяналт, мониторингийн газраас ирүүлсэн чиглэлийн хүрээнд хяналт шалгалтыг эрчимжүүлсэн ажлын тайланд үүрэг болгосон 5 чиглэлийг хийж гүйцэтгэсэн талаар тусгасан байна.

ХХҮЕГ-ын Хяналт, мониторингийн газрын 2020 оны 10 дугаар сарын 14-ний өдрийн “Дорнод аймгийн ХХҮГ-ын үйл ажиллагаа, төсвийн болон нийгмийн халамжийн сан, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих санд хийсэн шалгалтын тайлан”-д халамжийн үйлчилгээний чиглэлээр 6 зөвлөмж өгсөн байна.

Уг ажлын хүрээн илэрсэн зөрчил, дутагдлыг арилгах гүйцэтгэл сайжруулах төлөвлөгөөг 2020 оны 11 дүгээр сарын 02-ны өдөр баталж, халамжийн үйлчилгээний талаар өгсөн 6 зөвлөмжийг тусгаж, 2020 оны 11-р сарын 30-ны өдрийн

гүйцэтгэлийн тайланд биелэлтийг тусгаж тайлагнасан байна. 2021 онд цар тахалтай холбоотойгоор ХХҮЕГ-ын хяналт, мониторингийн газраас хяналт шалгалт хийгдээгүй байна.

3.2.2 Аймгийн ХХҮГ-аас халамжийн санд хийх дотоод хяналт шалгалтыг үр дүнтэй, үр нөлөөтэй зохион байгуулаагүй байна.

Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.2 дахь заалт “батлагдсан төсөв, хөтөлбөрийг хэрэгжүүлэх талаар төсвийн ерөнхийлөн захирагчтай байгуулсан гэрээний хүрээнд төсвийн хөрөнгийг удирдах, зарцуулалтад нь хяналт тавих”, 16.5.6 дахь заалтад “дотоод аудитын үйл ажиллагааг хэрэгжүүлэх” гэж төсвийн шууд захирагчийн эрх үүргийг тусгасан байна. Нийгмийн халамжийн тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.9 дэх хэсэгт “Аймаг, нийслэл, дүүргийн нийгмийн халамжийн үйлчилгээний байгууллага нь энэ хуулийн 24.8-д заасан чиг үүрэг бүхий ажилтантай байна” гэж заасан байна.

Аудитад хамрагдсан онуудад ХХҮГ-ын Дотоод хяналтын орон тооны бус нэгжийн эрсдэлийн төлөвлөгөөнд Халамжийн сангийн зарцуулалтад хяналт, шалгалт хийхээр тусгасан боловч хяналт шалгалтыг цаг үеийн нөхцөл байдлаас шалтгаалан 2022 онд хийхээр хойшлуулсан гэж төлөвлөгөөний биелэлтдээ тусгасан байна. ХХҮГ-аас халамжийн санд дотоод хяналт шалгалт хийхээр төлөвлөгөө гаргаж баталсан боловч төлөвлөгөөний биелэлтийг хангаж ажиллаагүй байна.

3.2.3 Халамжийн сангийн хүнсний эрхийн бичгийн үйлчилгээнд Мэргэжлийн хяналтын газраас 2021 онд хяналт, шалгалт хийсэн байна.

Нийгмийн халамжийн тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.7 дахь хэсэгт “Нийгмийн халамжийн мэргэжлийн хяналтыг Төрийн хяналт шалгалтын тухай хуулийн 9.1-д заасан мэргэжлийн хяналтын байгууллага хэрэгжүүлнэ”, Төрийн хяналт шалгалтын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.3.1 дэх заалтад “хуульд заасны дагуу хууль тогтоомж болон нийтээр дагаж мөрдөх эрх зүйн бусад актын биелэлтэд хяналт тавих” гэж заасан байна.

Энэ хүрээнд Мэргэжлийн хяналтын байгууллагын 2021 оны хяналт шалгалтын төлөвлөгөөнд тусгагдсаны дагуу Мэргэжлийн хяналтын Ерөнхий газрын даргын баталсан 2021 оны 01/71 дүгээр хяналт шалгалтын удирдамжаар Дорнод аймгийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын Нийгмийн халамжийн сангаас Хүнсний эрхийн бичиг олгох үйлчилгээнд, өрх иргэдийн хамруулсан байдал, зарцуулсан хөрөнгө, үр дүнд шалгалтыг хийсэн байна. Шалгалтыг 2020, 2021 оны 1-р улирлын олголт, түүний санхүүжилт зарцуулалтад анхан шатны баримтад тулгуурлан 14 сумын 2244 өрхийн хувийг тулган 50 хувийг түүвэрлэж хийсэн байна.

Дорнод аймгийн Мэргэжлийн хяналтын газрын 2021 оны 7 дугаар сарын 30-ны өдрийн 12-06-032/49 дугаар “Дорнод аймгийн Хөдөлмөр, халамж үйлчилгээний газарт хяналт шалгалт хийсэн дүнгийн тухай” хяналт шалгалтын танилцуулгад илэрсэн зөрчил дутагдал, хяналт шалгалтын явцад авсан арга хэмжээ, өгсөн зөвлөгөө, шалгуулагч этгээдийн эрсдэлийн үнэлгээ, цаашид авах арга хэмжээний санал зэргийг тусгасан байна.

ХОЛБОГДОХ БАЙГУУЛЛАГЫН САНАЛ:



ДОРНОД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ХЭРЭГЖҮҮЛЭГЧ АГЕНТЛАГ

ХӨДӨЛМӨР, ХАЛАМЖИЙН
ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ГАЗАР

21073, Чойбалсан, Дорнод аймаг

Утас/Факс: 7058-4306

2022.11.11 № 1/617

танай _____ -ны № _____ -Т

Г ДОРНОД АЙМАГ ДАХЬ Т
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Б.БОЛОРТУУЛ ТАНАА


Таны амгаланг айлтгая.

Дорнод аймаг дахь Төрийн аудитын газраас
“Аймгийн халамжийн сангийн үйл ажиллагааны үр
нөлөө”-д хийсэн гүйцэтгэлийн аудитын тайлангийн
төсөлтэй танилцлаа.

Цаашид аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлж
ажиллана.

Хүндэтгэсэн,

ДАРГА



Н.БАЗАРРАГЧАА

Б.Баттөрбаяр

Монгол улс, хариу
цаасан хавсралт.

2022.11.11

500620186

ДҮГНЭЛТ:

Аудитын явцад цуглуулсан нотлох зүйлс, аудитын дүнд үндэслэн дараах дүгнэлтийг хийж байна. Үүнд:

1. “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлоготой уялдуулан Нийгмийн халамжийн тухай хууль, журам, зааварт өөрчлөлт, шинэчлэлт хийгээгүй байна.
2. Халамжийн үйлчилгээнд шаардлагатай хөрөнгийг тооцоо судалгаанд үндэслэн төлөвлөөгүй байна.
3. Халамжийг хавтгайруулан олгож, зорилтод эмзэг бүлэгт чиглүүлээгүй байна.
4. Халамжийн үйлчилгээг үзүүлэхдээ давхцалыг тооцон үздэггүй байна.
5. Нийгмийн халамжийн үйлчилгээнд дундаж болон дунджаас дээгүүр амьдралтай өрх-иргэн хамрагдах боломжтой байна.
6. Хүнсний эрхийн бичигт хамрагддаг өрх-иргэдийн амьжиргааны түвшингийн мэдээллийг шинэчилж, хүнс тэжээлийн дэмжлэг олгох үйлчилгээг үр дүнтэй хэрэгжүүлээгүй байна.
7. Аймгийн ХХҮГ-аас халамжийн санд хийх дотоод хяналт шалгалтыг үр дүнтэй, үр нөлөөтэй зохион байгуулаагүй байна.

Аудитаар нийт 204.2 сая төгрөгийн алдаа зөрчил илрүүлж, 145.7 сая төгрөгийн 4 албан шаардлага, 7 зөвлөмж өгч, 58.5 сая төгрөгийн олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээтэй холбоотой гарсан асуудлыг Прокурорын байгууллагад шилжүүлж, нэгдсэн тайланд оруулах 5 саналыг боловсруулсан.

САНАЛ:

Үндэсний аудитын газарт: Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яаманд зөвлөмж

1. “Алсын хараа-2050”-д заасан амьдралын баталгааг хангах нийгмийн хамгааллын үйлчилгээг хөгжүүлэх зорилтын хүрээнд нийгмийн халамжийн тухай хууль, тогтоомжид өөрчлөлт оруулах.
2. Халамжаас хөдөлмөрт гэсэн зорилттой уялдсан халамжийн үйлчилгээг үзүүлэх.
3. Халамжийн үйлчилгээнд зорилтод эмзэг бүлгийн иргэдийг бүрэн хамруулах.
4. Халамжийн үйлчилгээний давхцалыг тооцон үздэг байх.
5. Амьжиргааны түвшин тогтоох судалгааг зохион байгуулах.

ЗӨВЛӨМЖ:

Аудитын дүн дүгнэлтэд үндэслэн дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг холбогдох албан тушаалтнуудад зөвлөж байна. Үүнд:

Аймгийн Засаг дарга М.Бадамсүрэнд:

1. Засгийн газраас баримталж буй халамжаас хөдөлмөрт гэсэн зорилтыг аймгийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих бодлоготой үр дүнтэй уялдуулах.
2. Олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээнд орон нутгийн төсвөөс баталсан хөрөнгийн зарцуулалтад хяналт тавьж ажиллах. /Санхүүгийн хяналт, аудитын алба/

Дорнод аймгийн ХХҮГ-ын дарга Н.Базаррагчаад:

1. Халамжийн үйлчилгээнд шаардлагатай хөрөнгийг бодит тооцоо судалгаанд үндэслэн төлөвлөж байх.
2. Халамжийн үйлчилгээ үзүүлэх ТББ, ААН-үүдтэй гэрээ байгуулахдаа журамд заасан нөхцөлүүдийг тусгаж ажиллах.
3. Олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээг зорилтод бүлэгт хүргэж ажиллах.
4. Хүнс тэжээлийн дэмжлэг авсан иргэдийг журамд заасны дагуу хөдөлмөр эрхлэлтийн үйлчилгээнд хамруулах.
5. Аймгийн ХХҮГ-аас халамжийн санд хийх дотоод хяналт шалгалтыг үр дүнтэй, үр нөлөөтэй зохион байгуулах.

Аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлэн ажиллаж, биелэлтийг 2023 оны 11 дүгээр сарын 05-ны дотор Дорнод аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэх.



ДОРНОД АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОРЫН
ТУШААЛ

2022 оны 11 сарын 15 өдөр

Дугаар А/25

Чойбалсан хот

┌ Аудитын тайланг баталгаажуулах тухай ┐

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 29 дүгээр зүйлийн 29.2, 29.4, Монгол Улсын Ерөнхий аудиторов 2020 оны А/106 дугаар тушаалаар батлагдсан "Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журам"-ын 18 дугаар зүйлийн 18.9 дэх заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. "Аймгийн халамжийн сангийн үйл ажиллагааны үр нөлөө"-нд хийсэн гүйцэтгэлийн аудитын тайланг нэгдүгээр, аудитаар өгсөн албан шаардлагыг хоёрдугаар хавсралтаар тус тус баталгаажуулсугай.

2. Аудитын тайланг аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын дарга /М.Энхтөр/, аймгийн Засаг дарга /М.Бадамсүрэн/, аймгийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын дарга /Н.Базаррагчаа/ нарт тус тус хүргүүлсүгэй.

3. Гүйцэтгэлийн аудитаар өгсөн албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг ахлах аудитор (Б.Батжаргал)-т даалгасугай.



Б.БОЛОРТУУЛ

Дорнод аймаг дахь Төрийн аудитын газрын
дарга, тэргүүлэх аудиторын 2022 оны
11 дүгээр сарын 25-ны өдрийн 11/25
дугаар тушаалын хоёрдугаар хавсралт

Албан шаардлагын жагсаалт

№	Байгууллагын нэр	Албан шаардлагын дугаар	Албан шаардлагын дүн /сая. төгрөг/
1	Дорнод аймгийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар	01/289 ДОА-2022/32-ШТА-ГА	-
		02/290 ДОА-2022/32-ШТА-ГА	49.1
		03/291 ДОА-2022/32-ШТА-ГА	70.9
		04/292 ДОА-2022/32-ШТА-ГА	32.9
Нийт			152.9

Дорнод аймаг Хэрлэн сум, 7-р баг, аймгийн Засаг даргын
Тамгын газрын 2-р байр, 1, 2 давхарт
Утас: +976 7058-4203, 7058-4204, 7058-4207
И-мэйл: dornod@audit.gov.mn, Веб сайт: www.audit.mn